

*ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын газар хоорондын хэлэлцээрийн дагуу хийсэн зэрэгцээ аудитын тайлан*

## **ХИЛ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨТ БАЙДАЛ**



**ХИЛ ДАМНАСАН ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН УЛМААС  
ЭКОЛОГИ, ЭДИЙН ЗАСГИЙН БАГАГҮЙ ХОХИРОЛ УЧИРСААР  
БАЙНА**

## Агуулга

### Тайланг бэлтгэсэн:

### ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Захирал

Д.Ганбилэг

Аудитын менежер

Х.Баярмаа

Ахлах аудитор

Г.Цэдэнбалжир

Шинжээч

Б.Болормаа

Ц.Цолмон

Т.Батзориг

Ж.Ганчимэг

С.Пүрэвсүрэн

2012 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Вэб сайтаас үзнэ үү.

[www.mnao.mn](http://www.mnao.mn)

Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 262451, 261885 дугаарын утас, факсаар харилцана уу.

### Хаяг

Үндэсний аудитын газар  
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3  
Засгийн газрын IY байр  
Улаанбаатар хот 15160  
Монгол улс

Товчилсон үгийн жагсаалт.....	2
Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	4
Аудитын багийн бүрэлдэхүүн.....	4

<b>Бүлэг 1. Хилийн дагуух ойн сан, түүний ашиглалт, хамгаалал, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах ажлын үр дүн</b>	5
---	---

Ойн санг хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаарх зарим хэлэлцээрийн үр дүн хангалтгүй байна.....	5
--	---

<b>Бүлэг 2. Хил орчмын усан санг хамгаалах талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн</b>	12
--	----

Хилийн усыг хамгаалах талаар байгуулсан хэлэлцээр хэрэгжиж байна.....	12
---	----

Монгол Улсын Засгийн газраас хил орчмын гол, мөрөн, усан санг хамгаалах талаар хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ	14
---	----

Хил дамнасан зарим голуудын усны горим, чанарын төлөв байдал	14
--	----

Сэлэнгэ, Булган, Дорнод аймгуудад зарим аж ахуйн нэгжүүд хууль зөрчин үйл ажиллагаа явуулж байна	18
--	----

<b>Бүлэг 3. Хил орчмын ховор ургамал, амьтныг хамгаалах, тус бүс нутагт гарч буй хориотой ангийн зөрчлийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн</b>	20
---	----

Хил орчмын ховор ургамал, амьтныг хамтран судлах, хамгаалах талаарх гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт хангалтгүй байна	20
---	----

БОАЖЯ хил орчмын ургамал, амьтны аймгийг судлах, хамгаалах талаар холбогдох арга хэмжээг авсан байна	20
--	----

Хил орчмын хулгайн ангийн зөрчил сүүлийн жилүүдэд багассан байна	22
--	----

<b>Бүлэг 4.Хил орчмын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн хамтын ажиллагаа, түүний үр дүн</b>	23
---	----

Хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах ажил удаашралтай, хангалтгүй хэрэгжиж байна	23
---	----

Хэдийгээр хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг албан ёсоор байгуулагдаагүй байгаа боловч орон нутгийн түвшинд хамтран ажиллаж байна	24
--	----

Хөвсгөл аймагт зарим аж ахуйн нэгж, иргэн ТХГН-ийн тухай хуулийг зөрчсөн байна	26
--	----

### Дүгнэлт

### Зөвлөмж

27

29

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам (хуучнаар)
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд (хуучнаар)
ОХУ	Оросын Холбооны Улс
Буриадын БНУ	Буриадын Бүгд Найрамдах Улс
Тувагийн БНУ	Тувагийн Бүгд Найрамдах Улс
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ТХГНЗ	Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ДЦГ	Дархан цаазат газар
БЦГ	Байгалийн цогцолборт газар
МУИС	Монгол улсын их сургууль
SITES	Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци
ОБА	Онцгой байдлын алба
ХЦА	Хилийн цэргийн анги
ИНТОСАЁ	Олон улсын аудитын дээд байгууллага
ОБГ	Онцгой байдлын газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ХА	Хүлцэх агууламж
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль

## Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын газрын хооронд 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2012 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### Аудитын зорилт

Хилийн дагуу орших ой, нэн ховор ургамал, амьтан, гол мөрөн, усан сан, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Хилийн дагуух ойн сан, түүний ашиглалт, хамгаалал, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах ажлын үр дүн
- Хил орчмын гол, мөрөн, горхи, усан сангийн ашиглалт, хамгаалал
- Хил орчмын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн хамтын ажиллагаа, түүний үр дүн
- Хил орчмын ховор ургамал, амьтныг хамгаалах, тус бүс нутагт гарч буй хориотой ангийн зөрчлийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн

### Аудитын хамарсан хүрээ

Шинэ Засгийн газар бүрэн хэмжээгээр бүрдээгүй байсан бөгөөд аудитад хуучнаар БОАЖЯ, Усны газар, Ойн газар болон ЦУОШГ, ХХЕГ, ОБЕГ, МХЕГ, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгийн ЗДТГ, БОАЖГ(хуучнаар), МХГ, ОБА, ХЦА, түүний харьяа застав, хилийн дагуух зарим сум, орон нутгийн захиргаа холбогдох бусад байгууллагууд хамрагдсан болно.

Зэрэгцээ аудитад 2007-2011 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд 2012 оны 4 дүгээр сарын 15-наас 2012 оны 6 дугаар сарын 1-ний хооронд хийж гүйцэтгэв.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын газар хоорондын хэлэлцээр, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын болон Хамтарсан аудитын жишээ, зөвлөгөө гарын авлага<sup>1</sup>, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, судалгаа гаргуулах,
- Хилийн дагуух байгаль орчны төлөв байдалд хээрийн ажиглалт хийх, зураг авч баталгаажуулах,
- Гол, мөрний уснаас дээж авах, шинжлэх, нэгтгэн дүн шинжилгээ хийх.

<sup>1</sup>ИНТОСАИ-ийн Хүрээлэн буй орчны аудитын ажлын хэсэг. (2007). Аудитын дээд байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа: Хамтарсан аудитын жишээ, зөвлөгөө гарын авлага

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгаа, тайлан, тайлбарыг ажлын баримт материалд хавсаргав.

### **Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт**

Монгол Улсын хуулиуд, Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хооронд болон Буриадын БНУ-тай байгуулсан гэрээ, хэлэлцээр, протокол, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, уулзалтын тэмдэглэл, сургалт, судалгаа шинжилгээний ажлын тайлан, бусад холбогдох материалуудыг ашиглав.

### **Аудитын багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэг удирдаж, үе шатны болон явцын хяналтыг аудитын менежер Х.Баярмаа хэрэгжүүлж, тус газрын ахлах аудитор Г.Цэдэнбалжир, шинжээч Б.Болормаа, Ц.Цолмон, Т.Батзориг, Ж.Ганчимэг, С.Пүрэвсүрэн, мөн Булган аймгийн ерөнхий аудитор Д.Ганбаатар, ахлах аудитор Ж.Энхцоодол, Хэнтий аймгийн ерөнхий аудитор Д.Баатархуяг, шинжээч Ц.Энхтүвшин, Хөвсгөл аймгийн ааd°iõèé àóäèòì Ì.Ãáíáíëä, ахлах аудитор Г.Нямлхагва, Сэлэнгэ аймгийн Аудитын газрын шинжээч Г.Жавхлан, С.Бямбасүрэн, Дорнод аймгийн Аудитын газрын шинжээч Ц.Гансүх нар нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитад Ойн газрын ахлах мэргэжилтэн Ц.Чулуунбаатар, Усны газрын Монгол Улс ОХУ-ын хилийн усны асуудал хариуцсан комиссын нарийн бичгийн дарга Ж.Отгонбаяр, ХХЕГ-ын Хилийн хэлтсийн мэргэжилтэн н.Батзориг, ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн ахлах инженер Я.Эрдэнэбаяр, усны чанарын хяналт шинжилгээний техникч Э.Амарзаяа нар оролцов.

## Бүлэг 1.Хилийн дагуух ойн сан, түүний ашиглалт, хамгаалал, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах ажлын үр дүн

### Ерөнхий зүйл

1.1. 2011 оны байдлаар Монгол Улс нийт 18565,5 мянган га ойн сантай бөгөөд үүнээс ОХУ-ын Буриадын БНУ-тай Хөвсгөл аймаг 153,9 мянган га, Булган аймаг 219,5 мянган га, Сэлэнгэ аймаг 41,6 мянган га, Хэнтий аймаг 72,3 мянган га, Дорнод аймаг 79,3 га ойн сантай хиллэж байна.

1.2. ОБЕГ-ий судалгаагаар Монгол Улсын хил орчимд 2006 оноос 2012 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар 57 удаа ой, хээрийн түймэр гарсан ба үүнээс ОХУ-аас Монгол Улсын хил давж 49 түймэр, Монгол Улсаас ОХУ-ын хил давсан 8 түймэр бүртгэгдсэн байна.

1.3. Дээрх түймэрт 65,5 мянган га ойн сан, 307,5 мянган га тал хээрийн бүс нутаг, нийт 373,0 мянган га талбай шатаж, түймрийг унтраахад Онцгой байдлын албанаас 878 албан хаагч, орон нутгаас 2206 иргэн, нийт 3084 хүн, 222 автомашин техник хэрэгсэлтэй ажиллажээ.

### Ойн санг хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаарх зарим хэлэлцээрийн үр дүн хангалтгүй байна

1.4. Монгол Улсын БОАЖЯ, ОХУ-ын холбогдох байгууллагуудтай ойг нөхөн сэргээх, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах, ойн түймэртэй тэмцэх хамтарсан арга хэмжээг боловсруулах, ойн түймрийг цаг алдалгүй илрүүлэх, мэдээлэх, хамтын хүчээр урьдчилан сэргийлэх, унтраах зохион байгуулалт, техникийн нөхцлийг бий болгох талаар дараах хэлэлцээрүүдэд тусгасан байна. Үүнд:

- 1995 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн Монгол Улсын Байгаль орчны яам, ОХУ-ын Ойн аж ахуйн улсын албаны хооронд байгуулсан “Ойн аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээр,
- 1999 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн “Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөцийг зохистой ашиглах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Байгаль орчны яам, Буриадын БНУ-ын Экологи, байгалийн нөөцийн ашиглалтын улсын хорооны хоорондын хэлэлцээр.

1.5. Дээрх хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, ОХУ-ын Буриадын БНУ-ын Ойн аж ахуйн агентлаг, Өвөр байгалийн хязгаарын улсын Ойн алба, Тувагийн БНУ-ын Ойн аж ахуйн улсын хорооны хооронд 2010 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр хамтран ажиллах санамж бичигт М.Тунгалаг, М.В.Капустина, С.И.Манчин, В.В.Ланцев нар Дархан хотод гарын үсэг зурсан байна.

1.6. Санамж бичигт дараах заалтуудыг тусгажээ. Үүнд:

- *Хамтрагч талууд өөрсдийн хил орчим болон хил дамнан гарч байгаа ой, хээрийн түймэр, түймрийн аюулын талаарх мэдээ, мэдээллийг электрон шуудан, сансрын зураг, утсан холбоог ашиглан өөр хоорондоо шуурхай мэдээлэл солилцон тогтмол холбоотой ажиллах,*
- *Харилцан зөвшилцсөн хэлэлцээрийн үндсэн дээр хил орчмын болон хил дамнасан ой, хээрийн түймрийг унтраахад Монгол Улс, Буриадын БНУ, Тувагийн БНУ, Өвөр Байгалийн хязгаарын холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулах,*
- *Хил дамнан гарч байгаа томоохон түймэртэй хамтран тэмцэх талаар жилд нэгээс доошгүй удаа хамтарсан уулзалт зохион байгуулах,*

- Уулзалт ярилцлагад оролцогчид хоёр улсын хил дамнасан түймрийн улмаас ойн сан, ойн аж ахуйд учирсан хохирол, унтраахад гарсан зардлыг нөхөн олгох талаар арга хэмжээ авахыг ОХУ-ын болон Монгол Улсын Засгийн газраас хүсэх,
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх чиглэлээр хамтрагч талууд туршлага солилцох, мэргэжилтнүүдийн дунд сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах, сургалтанд хамруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.

1.7. Гэвч хил орчмын болон хил дамнасан ой, хээрийн түймэр олон удаа гарч багагүй хохирол учирч байхад санамж бичигт тусгагдсаны дагуу түймрийг унтраахад Монгол Улс, ОХУ-ын Буриад, Тувааёёí ÁÍÓ, Өвөр Байгалийн хязгаарын холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулах, хил дамнасан түймрийн улмаас ойн сан, ойн аж ахуйд учирсан хохирол, унтраахад гарсан зардлыг нөхөн олгох талаар хоёр тал санаачлагагүй ажилласан байна.

Дорнод аймгийн Баян–Дун суманд гарсан хил дамнасан түймэр



1.8. Ойн газраас ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар дараах ажлыг хийжээ. Тухайлбал;

- Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулинд мониторинг хийж, Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмэлторуулж УИХ-аар батлуулсан,
- Ойн экологи-эдийн засгийн шинэчилсэн үнэлгээтэй уялдуулан “Ой хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ын төсөл боловсруулж Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 254 дүгээр тогтоолоор батлуулсан,
- “Ойг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний загвар төлөвлөгөө”-ний төсөл боловсруулж Монгол Улсын Шадар сайд, БОАЖН-ын хамтарсан 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 48/А-267 дугаар тушаалаар батлуулсан,
- Ой бүхий 10 гаруй аймгийн БОАЖГ-ыг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах гар болон механик багаж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж, нийт 400 сая орчим төгрөгийн техник хэрэгслийг орон нутагт хуваарилсан,
- Хил дамнасан ой, хээрийн түймрээс хамгаалах ажлын хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын Хөмөл нэртэй газраас Дадал сумын Хэрэйн гол хүртэл 50-100 м өргөн, 120 км урт зурвасыг зориудын шатаах аргаар байгуулжээ.

1.9. Монгол Улсын ОБЕГ, ОХУ-ын холбогдох байгууллагуудтай үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах талаар дараах хэлэлцээрүүдийг байгуулжээ. Үүнд:

- 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр,
- 2004 оны 2 дугаар сард Монгол Улсын Гамшигаас хамгаалах ерөнхий газар, ОХУ-ын Буриадын БНУ-ын иргэний хамгаалалт, онцгой байдлын хэрэг эрхлэх хорооны хооронд “Байгалийн гамшиг, онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээр.

1.10. Дээрх хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх үүргийг Монгол Улсын ОБЕГ, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яам хүлээж, хамтарсан комиссын анхдугаар уулзалтыг 1995 оны 9 дүгээр сард Москва хотод зохион байгуулснаас хойш 17 жилийн хугацаанд нийт 12 удаа уулзалт зохион байгуулжээ.

1.11. Эдгээр уулзалтаар хоёр улсын онцгой байдлын салбар дахь харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох, тулгамдсан асуудлыг авч хэлэлцэхийн зэрэгцээ хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж болзошгүй онцгой байдалд анхаарал хандуулж, нөхцөл байдлын талаар харилцан мэдээлэх, шуурхай арга хэмжээ авах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байжээ.

1.12. 2006 онд Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд С.Отгонбаяр ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яамны сайд С.К.Шойгу нар Монгол Улсын Онцгой байдлын байгууллага, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах асуудал эрхэлсэн яам хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх протоколд гарын үсэг зуржээ.

1.13. Протоколыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны академид 4, Иргэний хамгааллын академид 2 албан хаагч зэрэг нийт 24 хүн үнэ төлбөргүй суралтаар, Байгалийн эрэн хайх, аврах отрядын аврагч бэлтгэх төвийн 8 удаагийн сургалтад 2008 оноос хойш 112 албан хаагч, Чита мужийн аврагч бэлтгэх төвийн сургалтад Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн ОБА-ны 62 аврагчид хамрагдсан байна.

1.14. 2008 онд ОБЕГ-ын тэргүүн комиссар Ц.Амгаланбаяр тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-д айлчлал, 2002 оны хамтын ажиллагааны протоколын биелэлтийг хэлэлцээд улсын нөөцийн чиглэлээр хамтран ажиллах, боловсон хүчин сургахаар тохиролцоо, 2009 оны айлчлалаар бие бүрэлдэхүүнийг сургах, мэргэжил дээшлүүлэх, сургалтад хамруулах, техникийн шинэчлэл хийх талаар ярилцан 2009-2012 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөг баталжээ.

1.15. Уг төлөвлөгөөнд тусгагдсан 11 арга хэмжээнд хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх талаар уулзалт зохион байгуулах, ойн түймрийг унтраах команд штабын сургалт зохион байгуулах зэрэг асуудлыг тусгасан байна.

1.16. Үүнээс үзэхэд, ОБЕГ байгалийн гамшиг, онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах, ой хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр боловсон хүчнээ мэргэшүүлж, чадавхжуулах сургалтад хамруулах, мэдээлэл солилцох ажилд түлхүү анхаарчээ.

1.17. “Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай” Засгийн газар хоорондын гэрээг 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдөр байгуулжээ.

1.18. Энэ хэлэлцээрийн 19 дүгээр зүйлийн 3-т “талууд ойн болон хээрийн түймрийг улсын хил давуулахгүй байх арга хэмжээ авна. Ойн болон хээрийн түймэр улсын хилд ойртсон тохиолдолд эрх бүхий байгууллагууд энэ тухай бие биедээ нэн даруй мэдэгдэнэ”, ...нөгөө талын нутаг дэвсгэрт түймэр тархсан тохиолдолд холбогдох байгууллага түүнийг унтраах хамтарсан ажиллагааг хэрэгжүүлнэ”. Хэрэв түймэр



хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тархаж эд материалын хохирол учруулбал эрх бүхий байгууллага нь холбогдох байгууллагын төлөөлөгчдийн оролцоотойгоор түймрийн хэмжээг тодорхойлж акт үйлдэнэ” гэсэн заалтууд хоёр улсын хэмжээнд бүрэн хэрэгжээгүй байна.

1.19. ХХЕГ-аас 2009-2012 оны 5 дугаар сарын 12-ны байдлаар гаргасан бүрэн бус судалгаагаар ОХУ-аас 24 түймэр, Монгол Улсаас 4 түймэр гарсан байна.

1.20. Орон нутгийн түвшинд дараах хэлэлцээрүүдийг байгуулан ажиллаж байна. Тухайлбал,

- 2010 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр “Хил дамнасан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гарсанхохирлыг арилгах асуудлаарх Монгол Улсын Дорнод, Хэнтий аймгуудын Онцгой байдлын хэлтэс, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшиг үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яамны Байгалийн хязгаар дахь ерөнхий газар хоорондын хэлэлцээр”-ийг Өндөрхаан хотод,
- 2005 оны 4 дүгээр сард “Монгол Улсын Завхан, Увс аймгийн Онцгой байдлын хэлтэс, ОХУ-ын Онцгой байдлын яамны Тувагийн БНУ дахь ерөнхий газар, Тувагийн БНУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдлын газрын хооронд Байгалийн гамшиг, онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг тус тус байгуулжээ.

1.21. Эдгээр хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улс, ОХУ-ын хил залгаа аймгийн онцгой байдлын байгууллагуудын хооронд ажлын уулзалтуудыг зохион байгуулж, хил орчмын онцгой байдлын үед хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа боловч гүйцэтгэлийг дүгнээгүй, хил дамнасан түймрийг хамтран унтраах ажлыг зохион байгуулаагүй байна.

1.22. ОХУ-тай хил залгаа аймаг, сумдын удирдлага хавар, намрын гал түймрийн аюултай үед хилийн уулзалтыг зохион байгуулж, ой, хээрийн түймэр гарсан үед мэдээллийг шуурхай дамжуулах, шаардлагатай тохиолдолд түймэр унтраахаар ажиллаж байгаа хүмүүсийг хялбарчилсан нөхцлөөр улсын хил нэвтрүүлэн хугацаа алдалгүй бага дээр нь түймрийг унтраах талаар хэлэлцэж, түймрийг унтраах хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргаж ОХУ-ын талд явуулж байгааг үргэлжлүүлж байгааг үргэлжлүүлж байна.

1.23. Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Хэнтий, Дорнод аймгууд ОХУ-ын хилийн дагуух ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Тухайлбал;

#### Хэнтий аймаг

- Тус аймаг 2008 оноос эхлэн жил бүр ОХУ-тай хиллэдэг улсын хилийн дагуу 170 км газарт 50-100 м өргөнтэй хамгаалалтын харлуулсан зурвас байгуулснаар тухайн нутагт хил дамнасан түймэр байхгүй болжээ.
- Аймгийн ОБХ Биндэр сумын “Амгалант” гэдэг газар мансардтай дүнзэн байшинг Засаг даргын нөөц хөрөнгөөр бариулж, хуурайшилтын улиралд 12 албан хаагч, автомашин, түймэр унтраах багаж хэрэгслээр хангагдсан 2 шуурхай бүлгийг 2008 оноос эхлэн хилийн ойролцоо ажиллуулж байгаа нь түймрийн үеийн шуурхай байдал, шууд гарах зардал, цаг хугацааг хэмнэсэн үр дүнтэй ажил болжээ.
- ОБХ Биндэр, Батширээт сумын малчидтай хамтран 46 км урт газар хагалж, хамгаалалтын зурвас байгуулан түймрийг тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан нь зохих үр дүнд хүрсэн байна.

#### Сэлэнгэ аймаг

- Аймгийн хилийн цэргийн заставууд, аймгийн ОБГ-тай хамтран “Хил хамгаалахад туслах орон тооны бус зөвлөл”-ийг байгуулан байнгын жижүүр, харуул, морьт эргүүлийг томилон ажиллуулж

байгаа нь түймрийн гаралтыг бууруулах, гарсан түймрийг эрт унтраах, цурманд оруулахад эерэг нөлөө үзүүлж байна.

**Хөвсгөл аймаг**

- Аймгийн ОБХ, Хилийн цэргийн 0257 дугаар анги, БОАЖГ “Хилийн дагуух ойг хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллах тухай” гурвалсан гэрээ 2012 оноос байгуулан ажиллаж эхэлсэн байна.

**Булган аймаг**

- Монгол Улсын Булган аймаг, ОХУ-ын Буриадын БНУ-ын Закаменск аймаг хооронд хамтран ажиллах гэрээг Засаг дарга нар 2009 онд 10, 2010 онд 11, 2011 онд 8 заалттай байгуулсан боловч тус гэрээнд хилийн дагуух байгаль орчин, ойг хамгаалах, түймрээс урьдчилан сэргийлэх, гол, мөрөн, усан сан, ховор ургамал, амьтны талаар заалт тусгагдаагүй байна.
- Мөн, сумын ЗДТГ, БОАЖГ-тай хамтран ажиллах талаар ажлын төлөвлөгөө гаргаж, гэрээ байгуулсан ч төлөвлөгөө, гэрээний биелэлтийг гаргаагүй, үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаагүй байна.

**Дорнод аймаг**

- Дэлхийн байгаль хамгаалах сангаас санхүүжүүлсэн Онон-Балж төслийн хүрээнд Баян-Уул сумын Хэрийн голоос Баяндун сумын Нэмнэн гэдэг газар хүртэл Монгол Улс, ОХУ-ын хилийн дагуу 50-100 метрийн өргөнтэй 75 км урт түймдүүй хамгаалах зурвас татсанаар хил дамнасан түймэр тухайн газарт гараагүй байна.

Хэнтий аймгийн Биндэр суман дахь ОБХ-ийн шуурхай бүлгийн болон  
Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын түймрийн харуулын пост



1.24. БОАЖЯ, Ойн газар, аймаг, сумын ЗДТГ-т хилийн дагуух бүс нутагт байгаль хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох зардлыг тэр бүр тусгайлан төлөвлөдөггүй, зөвхөн аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс л зарцуулж байна. Тухайлбал, 2008-2011 оны байдлаар Ойн газраас зарцуулсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал:

Хийгдсэн ажлууд	2008	2009	2010	сая төгрөгөөр	
				2011	Нийт
1 Ойн хээрийн түймрээс хамгаалах, сургалт сурталчилгаа явуулах, багаж хэрэгсэл авах	11,0				11,0
2 Ойн түймрийн хууль тогтоомжийг сурталчлах, сургалт, зөвөлгөөн, хяналт шалгалт хийх		12,5			12,5
3 Орос-Монголын хил дагуух түймрээс хамгаалах хэлэлцээр, сургалт, шторк цацалт, багаж, тоног төхөөрөмж худалдан авах, БОАЖС-ын А-98 тоот тушаалын дагуу ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг амжилттай зохион байгуулсан аймаг, сумдыг шалгаруулж шагнаж урамшуулах			55,0		55,0
4 Түймрийн харуулын цамхаг барих, зурагт хуудас, санамж бичиг хэвлэх, эх бэлтгэх, видео сурталчилгаа, богино хэмжээний нэвтрүүлэг, мэдээлэл солилцооны сүлжээ өргөтгөх, мэдээллийн самбар хэвлүүлэх				107,4	107,4
5 Ойн түймрийн механик багаж хэрэгсэл, машин механизм, РЛО худалдан авах				412,9	412,9
6 Түймрээс хамгаалах халз зурвас байгуулах				214,2	214,2
ДҮН	11,0	12,5	55,0	734,5	813,0

1.25. Хүснэгтээс харахад, 2008-2012 онд нийт 813.0 сая төгрөг зарцуулснаас 26.3 хувийг түймрээс хамгаалах зурвас байгуулах, 73.7 хувийг сургалт, сурталчилгаа, багаж хэрэгсэл авахад зарцуулсан байна.

1.26. Хил дамнасан ой, дүүдөөй түймрээс учирсан хохирлын хэмжээг тогтоох, үр дагаврыг арилгах талаар орон нутагт дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Тухайлбал,

*Дорнод аймаг*

- Дорнод аймгийн нутагт 2006-2012 оны хооронд 17 хил дамнасан түймэр гарснаас ОХУ-аас орж ирсэн нь 15, Монгол улсаас ОХУ руу гарсан 2 удаагийн тохиолдол бүртгэгдсэн боловч хохирлын хэмжээг бүрэн гүйцэд тооцоогүй байна
- Дорнод, Хэнтий аймгуудын ОБХ, ОХУ-ын ОБЯ-ны Байгалийн хязгаар дахь ерөнхий газар хооронд 2010 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэлэлцээр байгуулснаас хойш ОХУ-аас хил даван орж ирсэн түймрийн улмаас 336 га ой, 1297,1 мянган га хээрийн бэлчээр нутаг шатаж урьдчилсан байдлаар 939 сая төгрөгийн хохирол учирсан бөгөөд 2012 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Баяндун сумын Өёауудёёё ам, Дөчийн голд гарсан түймрийн хохирлын акт бүрэн гараагүй байна. Энэ түймрийн улмаас тус аймагт 1258,6 мянган га ой, тал хээрийн бэлчээр нутаг шатаж, урьдчилсан байдлаар 615.1 сая төгрөгийн хохирол учирч, түймэр унтрааж явсан аймгийн Онцгой байдлын албаны 4 ажилтан нас барж, 1 ажилтан хүндээр түлэгдсэн байна.

*Сэлэнгэ аймаг*

- Сэлэнгэ аймагт 2007-2012 оны хооронд нийт 23 ой, хээрийн түймэр бүртгэгдсэнээс 22 нь ОХУ-аас манай нутаг руу, харин манай улсаас 1 түймэр ОХУ-ын нутаг руу гарсан байх бөгөөд түймрийн улмаас 17.6 мянган га ой, 14.0 мянган га хээрийн бэлчээр нутаг тус тус шатаж, түймэр унтраахад гарсан шууд зардал 20 сая төгрөг болсон ч, экологийн хохирлын хэмжээг тооцоогүй байна.

*Булган аймаг*

- 2009 оны 5 дугаар сард ОХУ-аас Хөвсгөл аймгийн Эг-Үүр, Булган аймгийн Тэшиг сумын хойд хэсгээр хил дамжин орж ирсэн түймэрт 15 хоногт 115 хүн, 7 машин техник дайчлагдан 3,3 сая төгрөгийн зардал гаргаж, түймрийн улмаас 11,9 мянган га талбай шатаж 14,3 сая төгрөгийн хохирол учирсан байна.

*Хэнтий аймаг*

- Хэнтий аймгийн нутагт 2007-2012 онд ОХУ-аас 4 удаагийн түймэр хил дамнан орж ирснээр 115,0 мянга га ой, 215,8 мянган га бэлчээрийн талбай шатаж 72,2 сая төгрөгийн экологийн хохирол учирч, 219,5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Дорнод аймгийн Баяндун сумын Өивэртийн аманд гарсан түймэр



1.27. ОБЕГ-ын гаргасан судалгаагаар, 2006-2012 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар хил дамнасан түймэр 56 удаа гарч үүнээс ОХУ-аас 48 түймэр (Сэлэнгэ аймгаар 19, Дорнод аймгаар 15, Хэнтийн аймгаар 7, Хөвсгөл аймгаар 3, Булган, Завхан, Увс аймгийн нутгаар тус тус 1 түймэр) орж ирсэн бол Монгол Улсд Дорнод аймгаас 7, Сэлэнгэ аймгаас 1 түймэр ОХУ руу хил давж гарчээ.

1.28. ОБЕГ-ын мэдээнд үндэслэн Ойн газрын гаргасан судалгаагаар 2006-2009 оны хооронд Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс, Завхан зэрэг аймгийн улсын хилийн дагуух бүс нутгаар ой, хээрийн түймрийн экологи, эд материалд учруулсан хохирол, түймэр унтраахад гарсан нийт зардал 5,4 тэрбум төгрөг болсон байна. Хил орчмын бүс нутагт ой, хээрийн түймрээс экологи-эдийн засагт учруулсан хохирлыг өнөөг хүртэл бүрэн гүйцээ тооцоогүй байна.

1.29. “Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай” БОАЖС-ын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 394 дүгээр тушаалаар батлагдсан үнэлгээг эргэн харж шинэчлэх, “ой хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

1.30. Өнөө үед хил дамнасан ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэхэд зарцуулах хөрөнгө нь гарсан түймрийг унтраахад зарцуулах зардлын хэмжээнээс илүү чухал ач холбогдолтой учир Монгол Улсын Засгийн газар болон БОАЖЯ, түүний харьяа агентлагууд энэ асуудалд анхаарах цаг болсон байна.

## Бүлэг 2. Хил орчмын усан санг хамгаалах талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн

### Ерөнхий зүйл

2.1. Монгол Улс газар нутгийн байршлаараа усны гурван том хагалбарын заагт Ази, Номхон далайн бүс нутгийн хамгийн хур тунадас багатай харьцангуй өндөрлөг, хуурайшилт ихтэй хэсэгт оршдог бөгөөд нийт нутаг дэвсгэрт бүрэлдэх гол, мөрний усны нөөц нь 34,6 шоо км болно<sup>2</sup>.

2.2. Монгол орны хил дамнасан Сэлэнгэ, Хэрлэн, Онон, Зэлтэр, Цөх, Минж голууд Монгол Улсаас ОХУ-ын Буриадын БНУ-ын хилийг даван гадагшаа урсаж байна.

### Хилийн усыг хамгаалах талаар байгуулсан хэлэлцээр хэрэгжиж байна

2.3. Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газартай байгаль орчны салбарт хамтран ажиллаж байгаа нэг гол чиглэл нь хоёр орны хилийн усны харилцаа юм. Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газартай хамтран хил орчмын гол, мөрөн, усан санг судлах, хамгаалах, мэдээлэл солилцох талаар дараах хэлэлцээрүүдийг байгуулсан байна. Үүнд:

- Хилийн усны талаар анх 1974 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн “Сэлэнгэ мөрний сав газрын усыг зөв зохистой ашиглах, хамгаалах тухай” БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр,
- 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн “Усны аж ахуйн салбарт хилийн усаар хамтран ажиллах тухай” БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр,
- 1994 оны 2-р сарын 15-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд “Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээр,
- Улмаар дээрх хэлэлцээрүүдийг шинэчлэн, өргөжүүлж 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдөр “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” Монгол Олсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр,
- 1999 оны 2-р сарын 25-ны өдрийн “Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөцийг зохистой ашиглах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Байгаль орчны яам, Буриадын БНУ-ын Экологи, байгалийн нөөцийн ашиглалтын улсын хорооны хоорондын хэлэлцээр зэргийг тус тус байгуулан хамтран ажиллаж байна.

2.4. Хилийн усыг хамгаалах талаарх хэлэлцээрийг хэрэгжүүлэх Бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөгөөн 10 удаа, түүний хооронд ажлын хэсгийн уулзалтыг жил бүр хоёр талд ээлжлэн зохион байгуулсан байна.

2.5. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчөөр БОАЖЯ-ны дэд сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн орлогч буюу ажлын хэсгийн ахлагчаар 2005 оноос Усны газрын дарга нар ажиллаж байна.

2.6. Бүрэн эрхт төлөөлөгчид болон ажлын хэсгийн уулзалтуудаар дараах асуудлуудыг хэлэлцэж, хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- 1996 оны 4 дүгээр сарын 4-7-ны өдөр Улаан-Үүд хотноо болсон Бүрэн эрхтийн анхдугаар зөвлөгөөнөөр Бүрэн эрхтийн төлөөлөгчдийн ажлын дэг, Монгол-Оросын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, хилийн усны горим, хилийн усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаарх хамтын ажиллагааг эхлүүлэх, Сэлэнгийн сав газрын хил дамнасан усны чанарын аргачлал, дээж авах, мэдээлэл солилцох журмыг боловсруулсан,

<sup>2</sup>БОЯ. (2008). Байгаль орчны төлөв байдлын тайлан 2006 – 2007 он. Улаанбаатар. х.42-43

- 1999 оны 6 дугаар сарын 9-12-ны өдөр Улаанбаатар хотноо болсон Бүрэн эрхтийн II зөвлөгөөнөөр бохирдуулагч бодисын үзүүлэлт, усны чанарын норм, дээж авах, мэдээлэл солилцох журам ба хамтарсан сорьц авах акт, онцгой ба аюултай нөхцөлд хилийн усны объектуудын талаар мэдээлэл солилцох журмыг тус тус баталсан,
- 2000 оны 12 дугаар сарын 14-15-ны өдөр Улаан-Үүд хотноо болсон Бүрэн эрхтийн III зөвлөгөөнөөр хилийн уснаас сорьц авах, ажиглалтыг 13 цэг дээр явуулах, хилийн усны эрүүл ахуй, халдвар судлал ба хил орчимд амьдарч буй хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх, Сэлэнгэ мөрний сав газрын загасны нөөцийг тогтоох талаар хэлэлцсэн,
- 2001 оны 7 дугаар сарын 4-7-ны өдөр Улаанбаатар хотноо болсон Бүрэн эрхтийн IV зөвлөгөөнөөр “Сэлэнгэ мөрний сав газрын голуудын горим, түүнийг тооцох арга” цувралыг аахин хэвлэх ажлын төлөвлөгөө, “Сэлэнгэ мөрний сав газрын загасны нөөцийг тогтоох (2001-2003 он) ажил”-ын хөтөлбөр зэргийг баталсан,
- 2003 оны 7 дугаар сарын 2-7-ны өдөр Эрхүү хотноо болсон Бүрэн эрхтийн V зөвлөгөөнөөр “Сэлэнгэ мөрөн түүний цутгал голуудын бохирдлоос хүн амын эрүүл ахуйд үзүүлэх нөлөөлөл” (2003-2005 он)-ийн талаар судалгаа хийх хөтөлбөр, Сэлэнгэ мөрний сав газарт эрдэм шинжилгээний ажил хийх, түүний санхүүжилтийн талаар олон улсын байгууллагад хандах асуудлыг ярилцаж, усны чанарын хяналт тавих байнгын харуулуудыг хилийн гол (Сэлэнгэ, Хяраан, Минж, Онон, Хэр, Улз, Хиагт, Зэлтэр) дээр байгуулахаар тохиролцсон,
- 2006 оны 8 дугаар сарын 28-29-ний өдөр Улаанбаатар хотноо болсон Бүрэн эрхтийн VI зөвлөгөөнөөр Хилийн усны голуудаас зэрэгцээ дээжлэлтийг жилд 2 удаа авахаар тохиролцож, усны сорьц авах, усны чанарын асуудлаар мэдээлэл солилцох журамд хийсэн өөрчлөлтийг баталж, “Сэлэнгэ хил хязгааргүй гол” сэдэвт Ёлон улсын онол, практикийн бага хурлыг зохион байгуулах, хилийн усыг ашиглах, хамгаалах ажлын хүрээнд төлөвлөж байгаа төслийн (усан сан, усан цахилгаан станц барих, усны нөөцийг шилжүүлэн ашиглах) талаар харилцан мэдээлэхээр тогтсон,
- 2007 оны 8-р сарын 2-нд Улаан-Үүд хотноо болсон Бүрэн эрхтийн VII зөвлөгөөнөөр Хилийн усан сангуудын гидрохими ба ус зүйн мэдээлэл солилцож, хамтарсан ажлын хэсэг Сэлэнгэ, Дархан-Уул аймагт байрладаг 6 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, Сэлэнгэ мөрний сав газрын хэмжээн дэх цэвэрлэх байгууламжуудын талаар танилцуулсан,
- 2009 оны 12 дугаар сарын 22-25 өдөр Улаанбаатар хотноо болсон Бүрэн эрхтийн VIII зөвлөгөөнөөр Сэлэнгэ мөрний сав газар ажиллаж буй Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Сүхбаатар хотуудын цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцаж, цэвэрлэх байгууламжуудын түвшин хэвийн байгааг тэмдэглээд тэдгээрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатайг дурьдаж, “Сэлэнгэ мөрний сав газрын усны нөөцийн менежментийн нэгдмэл загвар боловсруулах” Монгол-Орос-Солонгос улсын хамтарсан төслийн хэрэгжилтийн талаар мэдээлсэн,
- 2010 оны 9 дүгээр сарын 15-17-ны өдөр Екатеринбург хотноо болсон Бүрэн эрхтийн IX зөвлөгөөнөөр “Хилийн усан сангуудын чанарын (гидрохимийн үзүүлэлтээр)” ба “Хилийн усны хяналт шинжилгээний (микробиологи ба вирусын үзүүлэлтээр)” хөтөлбөрүүдийг баталж, ОХУ-аас Ашинга голоор (Онон голын сав газар) бохирдол орж ирсэн мэдээллийн дагуу ОХУ шуурхай арга хэмжээ авсныг дурьдсан,
- 2011 оны 10 дугаар сарын 26-28 өдөр Улаанбаатар хотноо болсон Бүрэн эрхтийн X зөвлөгөөнөөр Монгол улсын “Ус” үндэсний хөтөлбөрөө (2010-2021 он) хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Хилийн усны нөөц, чанар, бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлох хяналтын цэг, лабораторийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод байгуулах” ажил тусгагдсаныг болон “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ мөрний сав газар дахь уул уурхайн 189 лицензийг цуцалсан талаар Монголын тал мэдээлсэн.
- “Байгаль нуурыг хамгаалах болон түүний ай сав газрын нутаг дэвсгэрийн нийгэм-эдийн засгийг 2012-2020 онд хөгжүүлэх” зорилтот хөтөлбөр батлагдсантай холбогдуулан хэрэгжүүлэх ажлын талаар ОХУ-ын тал мэдээлж, тус хөтөлбөрийн хүрээнд Хиагт хотод цэвэрлэх байгууламж барих санхүүжилтийг шийдвэрлэнэ хэмээн Оросын тал мэдээлжээ.

2.7. Тус хэлэлцээр нь амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд хэлэлцээр батлагдсанаас хойш хилийн усны болон онцгой байдал, үерийн талаар мэдээлэл солилцох, хилийн усны чанар, горимын байнгын ажиглалт хийх ажил үндсэндээ хэвшсэн байна.

2.8. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх гол алба нь ажлын хэсэг бөгөөд энэхүү хамтарсан ажлын хэсэг нь хилийн усны гадаргын болон газрын доорх усны нөөцөд мониторинг хийж, эрүүл ахуй, хилийн усны аж ахуйн ашиглалт, уул уурхайн үйлдвэрүүдэд хяналт тавьж, лабораторийн шинжилгээ хийлгэн цэвэрлэх байгууламжийн технологийн түвшинд шалгалт хийж ирсэн байна.

### **Монгол Улсын Засгийн газраас хил орчмын гол, мөрөн, усан санг хамгаалах талаар хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ**

2.9. Монгол Улсын Засгийн газраас хил орчмын гол, мөрөн, усан санг хамгаалах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- “Усны тухай” хуулийг 2004 онд баталж, хуулийн хүрээнд сав газрын усны чанарын хяналт тавьж, хилийн бүсэд бохирдол нэвтрүүлэхгүй байх талаар анхаарал тавин ажилласан байна.
- “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг 2009 онд баталж, хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд голын голдиролд алт олборлох, уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байсан 240 гаруй компанийн лицензийг хүчингүй болгосон байна.
- Усны бохирдол, экосистемийн доройтлыг багасгах талаар нилээд ач холбогдол өгч Сэлэнгэ мөрний сав нутгийн Монголын хэсгийн нийт талбайн 15,7%-ийг Монгол Улсын ТХГН-ын сүлжээнд хамруулж, улмаар өргөтгөх бодлого баримталж байна.


2.10. Монгол орны усан сангуудаас Сэлэнгэ мөрөн дэлхийн голуудын ангилалд бүртгэгдсэн бөгөөд сав нутгийн талбай 477060 км<sup>2</sup>, үүний 63 хувь буюу 299690 км<sup>2</sup> талбай манай улсын нутагт оршдог, дэлхийн өвд бүртгэгдсэн Байгаль нууранд нэн чухал ач холбогдолтой мөрөн юм.

2.11. Иймээс Геоэкологийн хүрээлэнгийн санаачлага, НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр (UNEP), тогтвортой хөгжлийн байгууллагуудын сүлжээ (NISD)-ний дэмжлэгээр БНСУ-ын Засгийн газрын Байгаль орчны хүрээлэн, K-Water Хүрээлэн, Муонжу-ийн Их сургууль, Байгалийн нөөц Ашиглалтын хүрээлэн хамтран “Сэлэнгэ мөрний усны менежментийн загвар” төслийг 2007-2010 онд Монгол-ОХУ-Солонгосын судлаачдын хамтарсан баг хэрэгжүүлж, бохирдол тархалтын өнөөгийн байдал хийгээд усны менежментийн алдаа оноог дэлгэрэнгүй гарган 3 боть бүтээл туурвисан байна.

### **Хил дамнасан зарим голуудын усны горим, чанарын төлөв байдал**

2.12. Монгол орондоо томоохонд тооцогдох Хойт мөсөн далайн ай савд хамаарах Сэлэнгэ мөрөн, Орхон гол, Номхон далайн ай савд багтах Онон гол дээрх зарим ус судлалын харуулуудын мэдээг нэгтгэн жилийн дундаж урсацыг харьцуулан үзэхэд, 1995-2000 оны хооронд Орхон голын жилийн дундаж урсац буурсан боловч 2000 оноос хойш тогтвортой байна.


2.13. Харин Сэлэнгэ мөрний жилийн дундаж урсац нэлээд хэлбэлзэлтэй байх боловч 15 жилийн дундажаас харахад ерөнхийдөө хэвийн, Онон мөрний жилийн дундаж урсац харьцангуй тогтвортой байгааг дараах зургаас харж болно. Гэхдээ 1995 оноос хойш уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ус багатай жилүүд үргэлжилж байна.



\*Эх сурвалж: Ус, цаг уур орчны хүрээлэн, Ус судлалын сектор

2.14. Аудитаар ОХУ-аас орж ирсэн Дорнод аймгийн Дөч гол, Хэнтий аймгийн Балж, Ашинга, Бөхөн, Хирхон, Хөмөл, Агац, Улиастай, Сэлэнгэ аймгийн Хиатг, Цөх, Монгол Улсаас ОХУ руу урсан гар÷ áóé Онон, Сэлэнгэ, Зэлтэр, Хиран голуудыг хамруулан 2012 оны 4, 5, 6 дугаар сард сорьц авч, зарим хэмжилтийг газар дээр нь гүйцэтгэж, химийн болон чанарын задлан шинжилгээг лабораторид хийж, үр дүнг нэгтгэн боловсруулж дүгнэв.


2.15. **Усны химийн найрлага.** ОХУ-аас орж ирэх áóé судалгаанд хамрагдсан голуудын усны шинжилгээний дүнгээс үзэхэд ихэнх голын усанд катионоос кальци /Ca<sup>2+</sup>/, анионоос гидрокарбонат /HCO<sub>3</sub>/-ын ион зонхилж, катионы харьцаа Ca<sup>2+</sup>>Na+K>Mg<sup>2+</sup>, анионы харьцаа HCO<sub>3</sub>>SO<sub>4</sub>>Cl байгаа нь тэдгээр голууд харьцангуй цэвэр цэнгэг устай болохыг харуулж байна.



2.16. Хиатг голын хувьд усны дээрх үзүүлэлтүүд их гарсан бөгөөд эрдэсжилт 497 мг/л байна.

2.17. Цахилгаан дамжуулах чанар нь усны химийн найрлага, эрдэсжилттэй шууд хамааралтай, түүнийг илтгэгч хэмжигдэхүүн бөгөөд Хэнтий аймгийн нутгаар ОХУ-аас орж ирэх áóé голуудаааñ ààñàí усны дээжүүдийн эрдэсжилт маш бага áóó 20.9- 78.1 мг/л байна.

2.18. Монгол Улсаас ОХУ руу гарч буй голуудын усны шинжилгээний дүнгээс үзэхэд, голын усанд катионоос кальци /Ca<sup>2+</sup>/, анионоос гидрокарбонат /HCO<sub>3</sub>/-ын ион зонхилж, катионы харьцаа Ca<sup>2+</sup>>Na+K>Mg<sup>2+</sup>, анионы харьцаа HCO<sub>3</sub>>SO<sub>4</sub>>Cl байгаа нь тэдгээр голууд харьцангуй цэвэр, цэнгэг устай болохыг харуулж байна.





Онон голоос усны дээж авч шинжилгээ хийж байгаа нь




2.19. **Усны чанар.** Шинжилгээнд хамрагдсан хилийн усны дээжүүдэд усны ууссан хүчилтөрөгчийн горим хэвийн, мөн төмөр, мөнгөн усны бохирдол ихэнх усны дээжинд илрээгүй ба харин усан дахь хялбар исэлдэх органик бодисын агууламжийг илтгэгч биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ<sub>5</sub>), перманганатын исэлдэх чанар (ПИЧ), аммонийн болон нитрит, нитратын азот, эрдэс фосфор, фтор, зэс, хар тугалга, цайр зэрэг үзүүлэлтүүд усны чанарын стандартаас их бохирдол хэд хэдэн цэг дээр илэрлээ. Тухайлбал, Хиагт, Балж, Агац, Бөхөн, Хирхон, Ашинга голын усанд усан дахь БХХ<sub>5</sub>-ийн агууламж усны чанарын стандартаас 1.2- 2.1 дахин их, усан дахь Хиагт, Балж, Агац, Бөхөн, Хирхон, Дөч голын усанд аммонийн азотын агууламж 1.1- 2.2 дахин их бохирдолтой байлаа.

ОХУ руу урсах Улз гол, Чулуун хороот дахь гүүрэн дээр тасарсан болон Дөч голын бохирдсон байдал



2.20. ОХУ-аас орж ирэх агац Балж, Ашинга, Бөхөн, Хирхон, Агац, Цөх, Хиагт голуудын усан дахь хүчилтөрөгч (O<sub>2</sub>)-ийн агууламжийг усны чанарын стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас их байгааг зургаас харж болно.



2.21. Харин Монгол Улсаас гарч буй Онон, Сэлэнгэ, Зэлтэр, Хүдэр голуудын усны ууссан хүчилтөрөгчийн горим алдагдаагүй, хэвийн байв.


Зэлтэрийн голоос дээж авч буй байдал



2.22. Судалгаанд хамрагдсан голын усны дээжүүдээс Буурын гол, Хиагт голын усан дахь аммонийн азотын агууламж усны чанарын стандарт (хүлцэх агууламж=0.5 мг/л-

ээс ихгүй байх)-аас 1.1-1.9 дахин их байна. Харин нитритийн азотын агууламж усны чанарын стандарт (хүлцэх агууламж= 0.02 мг/л-ээс ихгүй байх)-аас 8-9.6 дахин их бохирдолтой байлаа.

2.23. Хиагт голын усанд нитратын азотын агууламж маш их буюу усны чанарын стандарт (хүлцэх агууламж=9.0 мг/л)-аас 1.5 дахин, фосфор 6,6 дахин их байгаа нь Хирсан голын усанд хүлцэх агууламжийн хэмжээнд байв.



2.24. ОХУ-аас орж ирж буй Балж, Агац, Бөхөн, Хирхон голуудын усанд бснү биогенийн үзүүлэлтүүдээс аммонийн азот хүлцэх агууламжаас их илэрсэн бол Монгол Улсаас гарч буй голуудын хувьд хэвийн байгаа. Усан дахү хялбар исэлдэх органик бодисын агууламжийг илтгэгч биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн (БХХ<sub>5</sub>) агууламжийг усны чанарын стандарт (хүлцэх агууламж=3 мг/л)-тай харьцуулахад


Балж голын доод цэг, Агац, Бөхөн, Хирхон, Ашинга голын усанд 1.2-2.1 дахин их байа.


2.25. ОХУ руу урсан гарч буй Сэлэнгэ, Онон, Зэлтэр, Хүдэр голуудын усан дахү эрдэс, азотын агууламж хүлцэх агууламжаас их байх тохиолдол илрээгүй.

2.26. Гэвч Орхон-Сэлэнгийн бэлчирээс авсан дээжинд усан дахү нитритын азотын агууламж ХА-аас бага зэрэг буюу 1.3 дахин, Буурын голын усан дахү аммонийн азотын агууламж ХА-аас 1.8 дахин их байгаа нь судалгааны хугацаа хаврын шар усны үертэй давхцсантай холбоотой.

2.27. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутгаар урсан орж буй Хиагт голын ус бохирдол ихтэй байгаа бөгөөд энэ гол нь Буурын гол руу цутган Сүхбаатар хотын дундуур урсаж, улмаар Орхон гол, Сэлэнгэ мөрнийг бохирдуулах байнгын эх үүсвэр болж байна. Иймд, Хиагт голыа бохирдолгүй, цэвэр тунгалаг байлгах шаардлагатай байна.

2.28. **Усан дахү хүнд металлын агууламж.** Монгол Улсаас гарч бснү голуудаан дээжүүдүя хүнд металлын шинжилгээ бснү, усан дахү зэсийн агууламж усны чанарын стандартаар Cu=0.01 мг/л-ээс ихгүй байхаас <0.005-0.003 мг/л, хар тугалгын агууламж Pb=0.01мг/л-ээс ихгүй байхаас <0.005-0.005 мг/л, цайрын агууламж Zn=0.01мг/л-ээс ихгүй байхаас 0.0000-0.0685 мг/л-т тус тус хэлбэлзэж байгаа нь усны чанарын стандартаас бага байгааг зургааг харж болно.





2.29. ОХУ-аас орж ирæ áóé голуудáаí àāñáí усны дээжүүдýä хүнд металлын шинжилгээ õëëõýä, зэсийн агууламж стандартын хэмжээнд, хар тугалганы агууламж Хиагт голын усанд хүлцэх агууламжаас 2.7 дахин их, Улиастай, Балж, Агац, Бөхөн голын усанд нилээд их агуулагдаж байгаа боловч хүлцэх агууламжаас бага, Хөмөн, Ашинга голын усанд хар тугалга илрээгүй, Хиагт голын усанд цайрын агууламж 2 дахин их, бусад голын усанд стандартын хэмжээнд байá.

### Сэлэнгэ, Булган, Дорнод аймгуудад зарим аж ахуйн нэгжүүд хууль зөрчин үйл ажиллагаа явуулж байна

2.30. Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэр дэх алтны шороон ордын 15465А лицензийг “Шар нарст” ХХК 30 жилийн хугацаатай, харин молибдений ордыг “Монресориз” ХХК тус тус эзэмшиж байна. “Монресориз” ХХК-ийн суурин хилийн шугамаас ердөө 1-2 км-ийн зайтай оршиж байгаа бөгөөд санхүүжилт байхгүйн улмаас одоогоор үйл ажиллагаагаа зогсоогоод байгаа аж. “Шар нарст” ХХК-ийн орд газар нь “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг зөрчсөн байна. “Шар нарст” ХХК-ийн үйл ажиллагааг 2011 оны 10 дугаар сарын 18-ны өдөр аймгийн МХГ-ын дарга Д.Энхсайханаар ахлуулсан ажлын хэсэг шалгаж үйл ажиллагааг нь зогсоосон боловч одоогоор олборлолт хийх материал, тоног төхөөрөмжөө татсаар байна.

Шар нарсò ХХК, Мон ресоурс ХХК-ийн уурхайн бэлтгэл ажил болон ажилчдийн байрны байдал



2.31. Цаашид дээрх компаниудын хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоох талаар холбогдох газар, албан тушаалтнууд анхааралдаа авч хуулийн дагуу шийдвэрлэх шаардлагатай байна.

2.32. Булган аймагт “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн 4.1 дэх “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно” гэсэн заалтын дагуу хил орчмын ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгоогүй байна.

2.33. Булган аймгийн Тэшиг сумын нутагт нийт 10 аж ахуйн нэгж хайгуулын 11, ашиглалтын 5 талбаа тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Тэдгээрээс зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцав. Тухайлбал,

- Булган аймгийн Тэшиг сумын 3 дугаар багт байрлалтай “АФК-Тавт” ХХК-ийн Тавтын алтны үндсэн ордын уурхай нь сумын Засаг даргатай гэрээ байгуулан 2010 онд 7169.1 мянган төгрөг, 2011 оны 09 дүгээр сард ус ашигласны төлбөрт 35796.9 мянган төгрөг оруулахаас 14000.0 мянган төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлсэн боловч гэрээгээ дүгнүүлээгүй, хэдий хэмжээний олборлолт хийсэн нь тодорхойгүй, 2011 онд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, уулын ажлын төлөвлөгөө, усны дүгнэлт зэргийг батлуулаагүй, улсын байцаагчдын өмнө өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг хэрэгжүүлээгүй байгаа нь “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 6.1 дэх заалт, “Газрын хэвлийн тухай” хуулийн 41.1 дэх заалт, “Усны тухай” хуулийн 26.1, 33.1 дэх заалтууд, “Ашигт малтмалын тухай” хуулийн 39.1.5 дахь заалт, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 13.2 дахь заалт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 28.1.13 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тус компанийн үйл ажиллагааг зөрчлийг арилгах хүртэл түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан ч өнөөг хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй байна.

### “АФК Тавт” ХХК-ийн далан сэтэрсэн байдал



- “Азаргын гол чонот” ХХК нь 4 дүгээр заставын хилийн 527 дугаар баганаас 2.5 км зайд 2007 онд жилд 6-9 дүгээр сард улирлын чанартай үйл ажиллагаагаа үргэлжлүүлж аааааа аааааа аааааа аудит хийх үед аааааа ий эхлээгүй, 2 харуул, 6 морь, 7 техник буюу үйлдвэр ааааа.
- Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэр дэх усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс тогтоох дүгнэлтээр Түргэн багийн нутагт Баруун бүтүүгийн шороон ордод үйл ажиллагаа явуулж буй №3206А тусгай зөвшөөрөл бүхий “Хөөсгөл” ХХК, №1492 тусгай зөвшөөрөл бүхий “Бугсаг” ХХК-ийн талбай орсон боловч 35 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулахаар бэлтгэж байлаа. Тус компанийн инженер Ганзориг уурхайн үйл ажиллагаа явуулах ямар нэгэн бичиг баримтыг үзүүлээгүй бөгөөд орд газрын талбайн давхцалыг арилгахаар хөөцөлдөж байгаа, уулын ажлын төлөвлөгөө батлагдсан, хилийн болон бусад зөвшөөрөл захирлаар ирнэ гэсэн тайлбарыг бичгээр өгсөн. Гэвч үүнийг ХХЕГ-аас тодруулахад хилийн бүсэд ажиллах албан ёсны зөвшөөрөл олгоогүй байна.

### “Хөөсгөл” ХХК-ийн уурхайн үйл ажиллагаа



Улсын хилээс 200 метр хүрэхгүй зайд, хилийн харуулын байрны дотор талд ХХЕГ-аас зөвшөөрөл авалгүй “Хөөсгөл” ХХК-ийн 30 гаруй ажиллагсад алт олборлох үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаад талд нь ОХУ-ын нутагт түймэр гарч буй байдал харагдаж байна.

### Бүлэг 3. Хил орчмын ховор ургамал, амьтныг хамгаалах, тус бүс нутагт гарч буй хориотой ангийн зөрчлийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн

#### Ерөнхий мэдээлэл

3.1. Монгол Улс нь Биологийн олон янз байдлын тухай конвенцид 1993 онд, Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци (CITES)-д 1996 онд, Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид 1997 онд, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Боннын конвенцид 1999 онд тус тус нэгдэн орсон байна.

3.2. Монгол орны Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгуудын ОХУ-ын Буриадын БНУ-тай хил залган орших бүс нутагт Монгол Улсын Улаан ном (1997), CITES-ийн I, II хавсралт (2000), Монгол Улсын ховор амьтны жагсаалт (1995)-д баданга хүдэр, молцог хандгай, халиун буга, цаа буга, зэрлэг гахай, янгир ямаа, дэлдэн зараа, алтайн чацуулан, хүрэн баавгай, голын халиу, шилүүс мий, мануул мий, саарал чоно зэрэг амьтад бүртгэгдсэн байна.

3.3. Мөн тус бүс нутагт CITES-ийн II хавсралт, Монгол орны ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн цоохор саадган цэцэг, шар саадган цэцэг, том цэцэгт саадган цэцэг, хөхөө цүнхрэг, шүрэн үндэс, сэрхэн хөхөө цэцэг зэрэг зүйл ургамлууд тархсан байна<sup>3</sup>.

#### Хил орчмын ховор ургамал, амьтныг хамтран судлах, хамгаалах талаарх гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт хангалтгүй байна

3.1. 1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн “Ургамал, амьтны аймгийг хамгаалах, судлах, түүний дотор ховор болон устаж үгүй болж байгаа дүрс зүйлийг нөхөн сэргээх арга хэмжээ авах”, 3 дугаарзүйлийн “Хамтын программ, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, ОХУ, Буриадын БНУ-тай хамтран хэрэгжүүлсэн судалгааны ажил, хамгаалалтын арга хэмжээ хангалтгүй байна.



3.2. Мөн тус хэлэлцээрийн 3 дугаар зүйл дэх “Ажлын хамтарсан хэсгүүдийг байгуулах” гээгээ заасны дагуу ургамал, амьтны аймгийн хамтарсан судалгаа, хамгаалаёдын арга хэмжээг хариуцсан ажлын комиссыг өнөөг хүртэл байгуулаагүй байна.

#### БОАЖЯ хил орчмын ургамал, амьтны аймгийг судлах, хамгаалах талаар холбогдох арга хэмжээг авсан байна

3.3. Зарим нэн ховор, ховор амьтдын амьдрах орчныг хадгалах, хамгаалах, зохистой ашиглах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах судалгааны ажлын хүрээнд дараах амьтдын тархац, нөөцийн судалгааг зохион байгуулсан байна. Тухайлбал<sup>4</sup>,

<sup>3</sup>БОЯ. (2008) Байгаль орчны төлөв байдлын тайлан 2006 – 2007 он. Улаанбаатар. х.64-65

<sup>4</sup>БОАЖЯ. (2011). Монгол улсын байгаль орчны төлөв байдлын тайлан 2008-2010 он. Улаанбаатар. х.41-42

№	Амьтны зүйлийн нэр	Нөөцийн судалгааг гүйцэтгэсэн		Нөөцийн тойм (толгой)	Хамрагдсан аймаг
		Он	Байгууллага		
5	Халиун буга	2010	ШУА-ийн Биологийн хүрээлэн	16800	Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Архангай, Увс, Баян- Өлгий, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Баянхонгор, Сүхбаатар, Төв зэрэг 13 аймаг
6	Бор гөрөөс	2010	ШУА-ийн Биологийн хүрээлэн	32000	
7	Зэрлэг гахай	2010	ШУА-ийн Биологийн хүрээлэн	38000	

3.4. Сүүлийн жилүүдэд амьтны аймгийг хамгаалах, ялангуяа агнуурын амьтны ашиглалт, хамгаалалтад оролцогч субъектуудын эрх үүрэг, ажлын уялдааг тодорхойлох, эдийн засгийн хөшүүргийг бий болгох, түүнчлэн агнуурын амьтны байршил нутгийг хамгаалахад нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоо, хараа хяналтыг дээшлүүлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах талаар эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулан гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байгаа ажээ. Тухайлбал<sup>5</sup>,

- Хувиргасан амьд организмын тухай хууль (2007),
- Ан агнуурын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль (2010),
- Амьтны аймгийн тухайхуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль (2010),
- Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль (2010) зэргийг УИХ-аар батлуулжээ.

3.5. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 105 дугаар тогтоолоор “Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталж, энэхүү хөтөлбөрийн хүрээнд ховор ургамлын удмын сан, тэдгээрийн тархац нутгийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зарим ургамлын биологи, экологийн судалгаа, төсөл санаачлагыг дэмжиж ажиллажээ. Тухайлбал<sup>6</sup>;

- Хөвсгөл аймагт Монгол Улсын Улаан номд орсон 34 зүйл, CITES-ийн хавсралтад бүртгэгдсэн 8 зүйл болон 31 зүйл нэн ховор, 56 зүйл ховор ургамал байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр тархац, нөөц нь хомсдож болзошгүй байгааг тогтоожээ.
- Эмчилгээний ашигт чанартай болон хүнсний зориулалтаар хэрэглэгддэг 382 зүйл ургамлын жагсаалтыг гаргаж, тэдгээрээс 195 зүйл эмийн ховор ургамлыг хамгаалах аргачлалыг эрдэмтэд боловсруулсан байна.
- ШУА-ийн Ботаникийн хүрээлэнтэй хамтран орон нутгийн иргэдэд ховор ургамлыг хамгаалах талаарх сургалтыг зохион байгуулж 300 гаруй унаган ургамлын үрийг цуглуулан үрийн санг баяжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.
- Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд 104 га талбайд чацаргана тарималжуулж ашиглах, Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Булган аймгийн Баяннуур орчмын нутагт 43 зүйл ургамлыг үрээр тарьж ургуулах туршилт амжилттай болжээ.
- МУИС-ын Ургамал судлалын тэнхим, ХААИС-ийн хамтарсан баг Монгол дагуур, Дорнод Монгол, Дундад халхын ургамал газар зүйн тойргийг хамруулсан судалгаагаар 80 гаруй нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах туршилт хийх шаардлагатай байгааг тогтоож, тэдгээрийн генофондыг байгуулах төслийг 2005-2007 онд хэрэгжүүлжээ.

3.6. Ургамлын аймгийг хамгаалахын тулд байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлж, ургамал хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, ашиглагчдад эдийн засгийн хариуцлага тооцох боломжийг бий болгох, ургамал ашигласны төлбөрийг сум, дүүргийн төсөвт шууд төвлөрүүлэх талаар дараах эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулан батлуулсан байна. Тухайлбал<sup>6</sup>;

<sup>5</sup>БОАЖЯ. (2010). 2010 оны үйл ажиллагааны тайлан. Улаанбаатар

<sup>6</sup>БОЯ. (2008). Байгаль орчны төлөв байдлын тайлан 2006 – 2007 он. Улаанбаатар. х.65-68



- Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль (2010),
- Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль (2010),
- Ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн-Хушны самрын идээний талаар 4 стандарт,
- Ургамлын нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээний суурь аргачлал зэргийг боловсруулж, батлуулсан байна.

### **Хил орчмын хулгайн ангийн зөрчил сүүлийн жилүүдэд багассан байна**

3.7. Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн Монгол-Орос Улсын хилийн дэглэмийн талаар байгуулсан хэлэлцээрт заасны дагуу Хөвсгөл аймаг дахь Хилийн цэргийн ангиуд ОХУ-тай хилийн цагийн байдлын талаар мэдээлэл солилцож, улсын хилийн дэглэмийн зөрчлийн судалгаанд тулгалт хийх асуудлыг хэлэлцэж, саналаа солилцдог байна.

3.8. Хөвсгөл аймгийн хэмжээнд 2008-2011 оны хооронд хил орчмын дэглэмийн зөрчлийн судалгаагаар нийт 35 зөрчил бүртгэгдсэнээс хулгайн антай холбоотой 7, байгалийн баялаг болох самар түүх 1, хаш олборлох 4 зөрчил бүртгэгдсэн байна. Хил орчмын дэглэм зөрчигчид гадаадын болон монгол иргэд ч байх бөгөөд зөрчил гаргасан иргэдэд хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч байна.

3.9. Дорнод, Хэнтий аймгийн хил орчмын бүс нутагт сүүлийн жилүүдэд ховор ургамал түүх, хориотой ан агнах зөрчил харьцангуй багассан байна.

## Бүлэг 4. Хил орчмын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн хамтын ажиллагаа, түүний үр дүн

### Ерөнхий зүйл

4.1. 1994 онд 1994 онд Монгол Улсын “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулиар газар нутгийг улсын тусгай хамгаалалтад дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэсэн дөрвөн ангиллаар тогтоосон нь олон улсын жишигт нийцүүлж, өөрийн орны онцлогт тохируулан тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг байгуулах, хамгаалалтын горимыг тогтоох үндэс нөхцөлийг бүрдүүлсэн байна.


4.2. БОАЖЯ улсын тусгай хамгаалалтад авах газар нутгуудын үндэслэл судалгааг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх, хөрш зэргэлдээ орнуудтайгаа хамтран хилийн дагуух экосистем, онгон байгаль, ургамал амьтнаа хамгаалах бодлого баримталж байна.

### Хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах ажил удаашралтай, хангалтгүй хэрэгжиж байна

4.3. Төрөл бүрийн ангилал, зохицуулалттай тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээ байгуулснаар зөвхөн биологийн төрөл зүйлийг хамгаалаад зогсохгүй, доройтолд орсон орчныг нөхөн сэргээх, ховор, ховордсон амьтан, ургамлыг өсгөн үржүүлэх бололцоо бүрдэх бөгөөд өнөөдөр тус улсын нутаг дэвсгэрийн 17 хувь буюу 26.70 сая га талбай бүхий 86 хэсэг газар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаад байна.

4.4. Тухайлбал, Хөвсгөл аймгийн нийт нутаг дэвсгэрийн 37.1 хувийг эзлэх 6, Булган аймгийн 18.2 хувийг эзлэх 5, Сэлэнгэ аймгийн 15.8 хувийг эзлэх 2, Хэнтий аймгийн 14.3 хувийг эзлэх 10, Дорнод аймгийн 14.3 хувийг эзлэх 8 тусгай хамгаалалттай газар нутаг тус тус байна.

4.5. Монгол Улсын Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгуудын ОХУ-ын Буриадын БНУ-тай хил залган орших бүс нутагт доорх зурагт тодруулан харуулсан Хөвсгөл–Түнхэн, Онон–Сохондын хил дамнасан тусгай хамгаалалттай газруудыг



байгуулахаар Засгийн газрын түвшинд олон жилийн өмнөөс төлөвлөж, Засгийн газар хоорондын удаа дараагийн уулзалт, хоёр талын Ерөнхийлөгч нарын албан ёсны айлчлалын үеэр ярилцаж байжээ.

4.6. Гэвч ОХУ-ын холбогдох байгууллагууд өнөөг хүртэл албан ёсоор гэрээ байгуулах ажил дээр хариу санал ирүүлэхгүй удах, хойшлуулах зэргээр санаачлага муутай ажиллаж иржээ.



4.7. Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын болон Буриадын БНУ-ын Засгийн газар хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрт тусгагдсан хоёр улсын хил дамнасан тусгай хамгаалалттай газруудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааг уялдуулах, хамтарсан *объект* газар *объект* байгуулах талаарх дараах зүйл заалтуудын хэрэгжилт удаашралтай, хангалтгүй байна. Үүнд:

- 1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Айгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай” бэлэлцээрийн 2 дугаар зүйлд “Онцгой хамгаалалтын нутаг дэвсгэрт явуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага” заалт,
- 1999 оны 2-р сарын 25-ны өдөр “Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөцийг зохистой ашиглах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Байгаль орчны яам, Буриад улсын Экологи, байгалийн нөөцийн ашиглалтын улсын хорооны хоорондын бэлэлцээрийн 1 дүгээр зүйлд “Онцгой хамгаалалтын нутаг дэвсгэрийн дэлхийн сүлжээний нэг чухал цэг болох Хөвсгөл-Саяны байгалийн цогцолборт газрыг хоёр талын сонирхогч байгууллагууд, мөн олон улсын болон бусад байгууллагуудын оролцоотойгоор байгуулах талаар хамтарсан үйл ажиллагаа явуулах” зэрэг заалтууд болно.

4.8. Хоёр улсын хил дамнасан тусгай хамгаалалттай газруудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааг уялдуулах, хамтарсан *объект* газар *объект* байгуулах асуудлаар ОХУ-ын талд санал тавьж, үүний дагуу хамтарсан комиссын II хуралдааныг 2008 онд Улаанбаатар хотноо зохион байгуулжээ. Тус хуралдаанд ОХУ-ын Байгалийн нөөцийн яам, харъяа газруудаас Хүрээлэн байгаа орчны департаментийн дарга А.Амирханов тэргүүлсэн 20 орчим хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцсон байна.

4.9. Тус уулзалтаар хэлэлцэгдсэн гол асуудлын нэг нь хоёр талаас олон жилийн турш ярьсан хил дамнасан *объект* газар *объект* байгуулах тухай байв. Мөн Хан-Хэнтий, Онон-Балж-Истоки Амура, Хөвсгөл-Түнхэний хил дамнасан *объект* газар *объект* байгуулах бэлтгэл ажлыг хангах, аль нэг тал нь хилийнхээ дагуух газрыг тусгай хамгаалалтанд авсан тохиолдолд нөгөө тал харилцан тусгай хамгаалалтанд авч байх зэрэг саналыг дэмжсэн байна.

**Хэдийгээр хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг албан ёсоор байгуулагдаагүй байгаа боловч орон нутгийн түвшинд хамтран ажиллаж байна**

*Онон-Сохондын сав газрын хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг*

4.10. Онон-Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа Олон улсын хил дамнасан хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Сохондын Шим мандалын дархан газрын захиргаатай 2003 оноос Хан-Хэнтийн ТХГН-ийн харьяанд байхаас эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна.

4.11. Хан-Хэнтийн ТХГН-ийн Хамгаалалтын захиргааны харьяанд хамгаалалтын хэсэг байх үед тухай үеийн удирдлагууд болох Д.Түмэнхүү, В.И.Яшнов нарын 2003 оны 10 сарын 14–ны өдөр байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд дараах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлжээ. Үүнд:

- Экосистем болон биологийн төрөл зүйлийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалах,
- Хоёр талын бүсэд амьдарч байгаа иргэдэд экологийн боловсрол олгох,
- Бүс нутгийн экосистемийг ойн болон тал хээрийн түймрээс хамгаалах,
- Хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэх, маршрутын дагуу эргүүл шалгалт хийх,

- Ховор, нэн ховор ургамал, амьтны хамтарсан судалгаа хийх,
- Хамтран хэрэгжүүлсэн ажлын хүрээнд гарсан ном товхимол, фото зураг солилцох,
- Хоёр талд туршлага солилцох зэрэг арга хэмжээг зохион байгуулжээ.

4.12. Онон-Балжийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа шинээр байгуулагдаж 2009 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Хамгаалалтын захиргааны дарга П.Гансүх, В.И.Яшнов нар хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан ба уг гэрээний хүрээнд дараах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байгаа аж. Үүнд:

- Жил бүр хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хоёр тал дүгнэн хэлэлцэх,
- Жилд хоёроос доошгүй удаа Онон-Балжийн БЦГ-ын ховор шувууд, цагаан зээр, голын халиу, мэрэгч амьтад (тарвага), тул загас болон ховор зүйлийн ургамлын судалгаа хийх,
- Хоёр талын хүүхдүүдийн дунд Олон улсын уран бүтээлийн уралдаан зохион байгуулж, шалгарсан хүүхдүүдийг хоёр талд амрааж аялуулах,
- Ой хээрийн түймэртэй тэмцэх, хяналт шалгалтын ажлын туршлагыг хоёр талд нэвтрүүлэх, туршлага солилцох,
- Хамтарсан судалгааны нэгдсэн арга зүйн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх,
- Биологийн төрөл зүйлийн болон байгалийн гамшэгийн тухай мэдээллийг солилцох зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлж байгаа ажээ.

*Хөвсгөлийн ТХГН-ийн Хамгаалалтын захиргаа, Түнхэний Үндэсний паркийн хамтын ажиллагаа*

4.13. Хөвсгөлийн ТХГН-ийн хил нь ОХУ-ын Буриадын БНУ-ын Окинский болон Түнхэн аймаг дахь Үндэсний паркийн нутаг дэвсгэртэй хиллэдэг байна. Хөвсгөлийн ТХГН-ийн Хамгаалалтын захиргаа Түнхэний Үндэсний паркийн захиргаатай хамтран хил дамнасан тусгай хамгаалалттай газруудыг байгуулах зорилгоор 2002 оноос эхлэн хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж, 2006 онд уг гэрээг шинэчлэн Олон улсын хамтран ажиллах 7 зүйл бүхий гэрээ болгон 6 жилийн хугацаатайгаар байгуулсан байна.

4.14. Энэ гэрээний хүрээнд туршлага, санал бодлоо солилцох, мониторинг, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, онцгой бүс дэх чонын тоо толгойн зохицуулалт хийх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамтарсан арга хэмжээ авах зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа тодорхойлсон байна. Эдгээр чиглэлийн хүрээнд эхний ээлжинд дараах 3 арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

- “Эко аялал ба хүүхдүүд” сэдэвт ажлын хүрээнд 2002-2006 онуудад тус хоёр байгууллага жил бүр ажилтан албан хаагчдын 18-20 хүүхдийг харилцан солилцож, эко аялал хийх, амраах,
- Хамтарсан баяр ёслол, урлаг соёлын арга хэмжээ, онол практикийн бага хуралд оролцох ажлын хүрээнд 2004-2005 онуудад ОХУ-ын Иркутск хотод зохион байгуулагдсан “Байкаль тур” үзэсгэлэн яармагт Хөвсгөлийн ТХГН-аас 3 ажилтан, “Марш парк” арга хэмжээнд 3 ажилтан,
- Мөсний баярын арга хэмжээнд Түнхэний Үндэсний паркаас 10 ажилтан тус тус оролцсон байна.

4.15. 2008 оноос “ОХУ-ын Түнхэний Үндэсний Парк, Хөвсгөлийн ТХГН-ийн хил дамнасан хамгаалалттай газар байгуулах хамтын ажиллагааг эхлүүлэх аялал”-ыг зохион байгуулжээ. Мөн мэргэжилтэн солилцож Түнхэний Үндэсний паркийн мэргэжилтэн Саян, Хөвсгөлийн ТХГН-ийн мэргэжилтэн Ё.Жамъянжав нар ажлын туршлага судлах зорилгоор энэ ажилд хамрагдаж байжээ.

4.16. Эдгээр ажлын хүрээнд хил дамнасан тусгай хамгаалалттай газрыг байгуулах үндэслэл боловсруулах, түүнийг орон нутгийн хөгжилтэй хэрхэн уялдуулах, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэг ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэн ажиллаж иржээ.

**Хөвсгөл аймагт зарим аж ахуйн нэгж, ёддүй ТХГН-ийн тухай хуулийг зөрчсөн байна**

4.17. Хөвсгөл аймаг дахь улсын ТХГН-т хамаарагдах Цагааннуур, Улаан-Уул суманд хууль бусаар алт, ногоолин чулуу олборлох үйл ажиллагаа явагдаж байна. Тухайлбал;

- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 06 сарын 17-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор“ (Аөёаd ìàèdìàèüí ààçдaас олборлолт хийх зөвшөөрөл олгогдоогүй байхад ЁОÖ-üí ääдäà Г.Буянтогтох гарын үсэг зурсан) иргэн Г.Мөнх-Очир, М.Ганзориг нарт сумын 2 дугаар багийн нутагт орших Бярангийн ногоолин чулууг ашиглах”-ыг зөвшөөрөё ìëäíñíí байна. Энэ тогтоол нь Тусгай хамгаалалттай газрын нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх “газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Улаан–Уул суманд хууль бусаар алт олборлож байгаа явдлыг таслан зогсоох үүднээс аймгийн Засаг дарга 2009 онд “Байгаль орчныг хамгаалах тухай” 81 тоот захирамж, 2010 онд “Хууль бус алт олборлолтын талаар авах зарим арга хэмжээний тухай” А-117 дугаар захирамж, 2011 оны 1 дүгээр сард “Ажлын хэсэг томилох тухай” 21 дүгээр захирамж, 2011 оны 9 дүгээр сард “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” А/311 дүгээр захирамжийг тус тус гаргаж, захирамжийн дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулсан боловч тухайн үед тодорхой үр дүн гараагүй байна.

## ДҮГНЭЛТ

Хил дамнасан ой, хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагаатай холбогдож дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улс болон ОХУ-ын Засгийн газрын хооронд байгуулагдсан гэрээ хэлэлцээрийн хүрээнд хил дамнасан түймэртэй тэмцэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй, төлөвлөгөө гаргаж ажиллахдаа урт богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах болон мэдээлэл солилцох ажилд голлон анхаарч иржээ.
- Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, ОХУ-ын Буриадын БНУ-ын Ойн аж ахуйн агентлаг, Тувагийн БНУ-ын Ойн аж ахуйн агентлаг, Өвөр Байгалийн хязгаарын улсын йн албаны хооронд байгуулсан санамж бичгийн дагуу ажиллаж байгаа ч зарим ажил хангалттай үр дүнд хүрэхгүй байна.
- Монгол Улс болон ОХУ-ын хилийн шугамын дагуу түймрээс сэргийлэх шороон зурвас арилсiú оéiààñ ОХУ-ààñой, хээрийн түймэр хил дамнан iðæ èðýí өргөжиж, экологи, эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулсаар байна. Мөн түймэрт өртсөн ойн сангийн талбайн экологи-эдийн засгийн хохирлыг тооцох асуудал хангалтгүй байна.
- Хавар, намрын хуурайшилт ихтэй үед ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны ажлыг хүчтэй болгох, түймэр тавьсан буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал хэрэгжихгүй байна.

Хил орчмын усан санг хамгаалах талаарх арга хэмжээ, түүний үр дүнгийн байдалд хийсэн аудитаар дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хилийн усыг хамгаалах, ашиглах тухай хэлэлцээр амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд хэлэлцээр батлагдсанаас хойшиõ хугацаанд хилийн усны талаар мэдээлэл солилцох, хилийн усны чанар, горимын талаар байнгын ажиглалт хийх, онцгой байдал үерийн талаар мэдээлэл солилцох ажил үндсэндээ хэвшсэн байна.
- Монгол Улсаас óðñàí гарч áóé Сэлэнгэ, Зэлтэр, Хяраан, Хүдэр голуудын усанд катионоос кальцийн, анионоос гидрокарбонатын ион тогтвортой зонхилж, харьцангуй цэвэр цэнгэг устай байна. Мөн Сэлэнгэ мөрөн, Орхон, Онон голын сүүлийн 15 жилийн дундаж урсац тогтвортой байна.
- Дээрх голуудад усны ууссан хүчилтөрөгчийн горим хэвийн, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ<sub>5</sub>), перманганатын исэлдэх чанар (ПИЧ), эрдэс азот, төмөр, фтор, зэс, хар тугалга, цайр, мөнгөн усны агууламж зэрэг нь усны чанарын стандартаас бага байна.
- ОХУ-аас орж ирæ áóé голуудын усны ууссан хүчилтөрөгчийн горим хэвийн, мөн төмөр, фтор, зэс, мөнгөн усны бохирдол илрээгүй бөгөөд харин Хиагт, Балж, Агац, Бөхөн, Хирхон, Ашинга голын усанд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ<sub>5</sub>), перманганатын исэлдэх чанар (ПИЧ), аммонийн болон нитрит, нитратын азот, эрдэс фосфор, хар тугалга, цайр зэрэг үзүүлэлтүүд усны чанарын стандартаас 1.2-2.1 дахин их, усан дахь аммонийн азотын агууламж дээрх голуудын усанд 1.1-2.2 дахин их бохирдолтой байна.

- Үүнээс Хиагт гол маш их бохирдолтой байсан бөгөөд усан дахь биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 1.7 дахин, аммонийн азот 1.1 дахин, нитритийн азотын агууламж 9.6 дахин их, нитратийн азотын агууламж 1.5 дахин, эрдэс фосфорын агууламж 6.6 дахин, хар тугалганы агууламж 2.7 дахин, цайрын агууламж 2 дахин их байлаа.
- Сэлэнгэ аймгийн Түшиг суманд “Шар нарст” ХХК, Дорнод аймгийн Баяндун сумын Шивэртийн аманд “Хөөсгөл” ХХК-иуд “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн заалтыг зөрчин үйл ажиллагаа явуулж байна.

Хил орчмын ховор ургамал, амьтныг хамгаалах, тус бүс нутагт гарч буй хориотой ангийн зөрчлийн талаар дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээрт тусгагдсан ургамал, амьтны аймгийг хамгаалах, судлах, нөхөн сэргээх, ажлын хамтарсан хэсэг байгуулах, хамтын программ, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.
- БОАЖЯ ОХУ, Буриадын БНУ-тай хамтраагүй ч гэсэн хил орчмын зарим нэн ховор, ховор амьтдын амьдрах орчныг хадгалах, хамгаалах, зохистой ашиглах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах, ховор ургамлын удмын сан, тэдгээрийн тархац нутгийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зарим ургамлын биологи, экологийн судалгаа, төсөл санаачлагыг дэмжиж ажилласан байна.
- Хөвсгөл, Хэнтий, Дорнод аймгуудад хил орчмын бүс нутагт сүүлийн жилүүдэд ховор ургамал түүх, хориотой агнуурын зөрчил буурсан, харин Сэлэнгэ аймагт сүүлийн 10 жилийн хугацаанд хилийн дагуух хулгайн ангийн зөрчлийн талаарх судалгаа алга байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн хамтын ажиллагааны талаар дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улс хөрш зэргэлдээ орнуудтайгаа хамтран хилийн дагуух экосистем, онгон байгаль, ургамал амьтнаа хамгаалах бодлого баримталж, ОХУ-тай хамтран Хөвсгөл-Түнхэн, Онон-Сохонд зэрэг газруудыг хамруулан хил дамнасан ТХГН болон Олон улсын шим мандлын нөөц газар байгуулахаар төлөвлөж байгаа боловч энэ ажил удаашралтай байна.
- Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газартай хамтран хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг албан ёсоор байгуулаагүй хэдий ч Онон-Балжийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа 2003 оноос ОХУ-ын Сохондын Шим мандалын дархан газрын захиргаатай, Хөвсгөлийн ТХГН-ийн Хамгаалалтын захиргаа 2002 оноос Түнхэний Үндэсний паркийн захиргаатай тус тус хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан байна.
- Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул сумын нутаг дэвсгэрт Тóñāàé òāīāāāēāēòòāé āāçāð íòòāēēí тухай хуулийг зөрчин хууль бусаар алт, ногоолин чулуу олборлох үйл ажиллагаа явагдаж байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### Монгол Улсын Засгийн газарт

1. Хил дамнасан түймрийг унтраах талаар авч буй арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийж, хил орчмын бүс нутагт ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар Засгийн газар хоорондын баримт бичгийг батлах боломжийг судлах;
2. Хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн шугамын дагуу хамгаалалтын шороон зурвас шинээр байгуулах буюу сэргээх арга хэрэгжүүлэх;
3. 1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн “Байгаль орчны салбарт хамтран ажиллах тухай”, 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх зохион байгуулалт-эрх зүйн механизмыг боловсронгуй болгож, хамтарсан комисс, бүрэн эрхт төлөөлөгчид зохих статус, бүрэн эрх олгох;
4. Хамтарсан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.

### Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд

1. Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон хөрш зэргэлдээх Бүгд Найрамдах Улсуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр, санамж бичгийн хэрэгжилтийг дүгнэж, олон нийтэд мэдээлж ажиллах;
2. Хил орчмын гол, мөрний мониторинг судалгааны сүлжээг өргөжүүлж, байнгын ажиллагаатай болгох, усны чанарын шинжилгээний суурин болон явуулын лабораторийг байгуулж, орчин үеийн техник, технологиор тоноглох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлэх;
3. Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар хоёр улсын орон нутгийн төр, захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх;
4. Ойн сангийн экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлалыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хил дамнасан түймрээс учирсан хохирлыг бүрэн тооцож ажиллах;
5. Түймэр тавьсан буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог чангатгах;
6. Хилийн бүс нутаг дахь хууль бус агнуур, ургамал түүж бэлтгэх болон биологийн төрөл зүйлийн шилжилт хөдөлгөөн, байршил, тархац, тоо толгойн нөөцийн талаар холбогдох байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, хамтарсан хяналт шалгалт хийх ажлыг тогтмолжуулах;
7. Хөвсгөл–Түнхэн, Онон-Сохондын сав газар зэрэг хил дамнасан ТХГН-ийг байгуулах бэлтгэл ажлыг хангаж, хэрэгжүүлэх.

### **Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Ө.Орхон Т. Дуламдоржид**

1. Хилийн дагуух болон хил дамнасан ой хээрийн түймрээс сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг зохицуулсан 2 улсын гэрээ хэлцэл, эрх зүйн орчинг эргэн харж боловсронгуй болгох санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.
2. Хил дамнасан ой, хээрийн түймрээс сэргийлэх, 010000 зориоёо Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Увс зэрэг аймгуудын Онцгой байдлын албадыг түймэр унтраах зориулалтын техник, багаж хэрэгслээр хангах.

### **Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч хошууч генерал Ц.Сэргэлэнд;**

1. Хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Увс аймгуудад хилийн шугамын дагуу хамгаалалтын шороон зурвасыг сэргээх буюу шинээр байгуулах, хилийн заставуудыг түймэр унтраах зориулалтын техник, багаж хэрэгслээр хангах хөрөнгийн эх үүсвэрийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
2. Хил хамгаалах анги болон хилийн заставуудыг түймэртэй тэмцэх техник, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах.

### **Хил орчмын аймаг, Ө.Орхон ИТХ болон Засаг дарга нарт:**

1. Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Увс зэрэг аймаг, сумд00 түймэр унтраах зориулалтын техник, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж, ажиллах;
2. Ойн тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавьж, ой хээрийн түймрээс учирсан хохирлыг зохих журмын дагуу тооцон буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг сайжруулах;
3. Хавар, намрын хуурайшилт ихтэй үед ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны ажлыг хүчтэй болгох.

Холбогдох байгууллагын санал

БОАЖА-ны  
санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26-61-71, Факс: (976-51) 26-62-86,  
E-mail: monenv@mail.mn, http://www.mne.mn

2012.07.05 № 3/2849  
танай 2012.07.02 -ны № 888 -Т

Тоотын хариу

Танай 2012 оны 7 дугаар сарын 02-ны 838 албан бичигтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

“Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөө”-т байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл, дүгнэлтийг дэмжиж байна. Харин Монгол Улсын Засгийн газарт өгөх зөвлөмжид:


“Хил орчмын байгаль орчны хэлэлцээр байгуулахыг улмаар хилийн усны болон хил дамнасан ой хээрийн түймрээс сэргийлэх хэлэлцээрүүдийг нэгтгэж асуудлыг нэг мөр экосистемийн хүрээнд шийдэх” гэсэн заалтыг нэмж оруулах санал дэвшүүлж байна.

Учир нь хилийн усны бохирдолтой тэмцэх, шийдвэрлэх болон хилийн усны харилцааны талаар 2 орон хэвийн харилцаатай явж ирсэн.

Хэдий тийм боловч усны асуудлыг ярихдаа ус бүрэлдэх үйл явцад хамгийн их нөлөөтэй байгалийн бүрдэл хэсэг болох ойн асуудлыг орхигдуулж болохгүй юм. Ийм учраас байгалийн өөрийнх нь жам ёсны харилцан бие биенээ тэтгэсэн үйл явцыг тогтвортой хадгалах, улмаар цаашид тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлэхийн тулд байгалийн бүрдэл хэсгийг дан дангаар нь бус харин цогц байдлаар асуудалд хандах шаардлагатай байна.

Тайлбар 1

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Н.БАТСУУРЬ

001001



Ойн газрын  
санал



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ОЙН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44,  
Засгийн газрын III байр, Утас/Факс: (976-51) 26-64-33,  
E-mail: fam@forestry.gov.mn

2012.07.05 № 2/798  
танай 2012.07.02 -ны № 3/839 -г

Албан бичигт хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн "Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал" нэр бүхий тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайланд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Зөвлөмж хэсэгт: Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ болон Засаг дарга нарт гэж тусгайлан авч үзээд;

1. Ойн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 17, 18 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ болон Засаг даргын бүрэн эрх, 17.1.1., 18.1.1 дахь хэсгийн заалт "...ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих" гэсэн заалтыг биелүүлэх, хэрэгжүүлэх.
2. Хавар, намрын хуурайшилтын үед ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ухуулга, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, түймэр тавьсан буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, хохирлыг нөхөн төлүүлж байх.
3. Засгийн газрын 2010 оны 09 дүгээр сарын 29 -ний өдрийн 254 -р тогтоолоор батлагдсан "Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам" -г хэрэгжүүлж, хяналт тавих.

Тус тайлангийн төсөлд өгөх өөр саналгүй болохыг уламжилж байна.

ДЭД ДАРГА



Д.БОЛДМЯГМАР

Тайлбар 2

Усны  
газрын  
санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УСНЫ ГАЗАР**

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,  
Чингүнжавын гудамж, Утас: 30-00-75

2012.07.04 № 3/302  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал өгөх тухай


“Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаар төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал”-д танай газраас 2012 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Тайлангийн төслийн:

- Бүлэг 2 Хил орчмын усан санг хамгаалах талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн хэсэг-ийн 2.6 дахь Улаан-Үүд гэснийг Улаан-Үд, 2.28 дахь Хөмөн гол гэснийг Хөмөл хэмээн засварлах,
- Товчилсон үгийн жагсаалтад ИНТОСАИ, ОБЯ, ОБХ, ХА, МУИС, ХААИС гэсэн үгнүүдийн тайлбарыг нэмж өгөх нь зүгээр болов уу.

Аудитын тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.

ДАРГА



Ц.БАДРАХ

081033

Онцгой  
байдлын  
ерөнхий  
газрын  
санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Партизаны гудамж, Утас: 26-35-64, Факс: 32-49-77  
E-mail: doc@nema.mn; http://www.nema.mn

2012.07.06 № 1/1548  
танай 2012.07.02 ны № 3/839 -Т

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
Д.ГАНБИЛЭГ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Танай газраас ирүүлсэн "Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тайлбар 3

Тайлангийн хил дамнаж орж, гарсан түймрийг тархсан тохиолдолд түүнийг унтраах хамтарсан ажиллагааг хэрэгжүүлээгүй гэсэн 1.19 дэх заалтад Засгийн газар хоорондын гэрээний дагуу:

-2007 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Завхан аймгийн Тэс сумын нутагт хилийн 245, 246 тэмдэгтээр орж ирсэн түймэр дээр ОХУ-аас 40 алба хаагч,

-2011 оны 03 дугаар сарын 31-ны өдөр Дорнод аймгийн Чулуунхороот сумын нутаг "Шар ус" гэдэг газраар хилийн 57 дугаар отрядын 7 дугаар заставын хариуцсан хилийн 858-859 дүгээр, хилийн 31 дүгээр отрядын 9 дүгээр заставын хариуцсан хилийн 964 дүгээр тэмдэгтүүдийн чиглэлээр ОХУ-ын талаас орж ирсэн хээрийн түймэр дээр 7 албан хаагч, 1 автомашинтай,

-2009 оны 05 дугаар сард Дорнод аймгийн Халх гол сумын нутагт гарсан хээрийн түймэр дээр БНХАУ-аас 197 хятад иргэн,

-Дорнод аймгийн Баян-Уул сумын нутаг хилийн 841 дүгээр тэмдэгтээр 2009 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ОХУ-аас орж ирсэн ой, хээрийн түймэр дээр ОХУ-аас 15 алба хаагч, 3 автомашинтай,

-2012 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Увс аймгийн Давст сумын хилийн 167.5 дугаар тэмдэгтийн орчим гарсан түймэр дээр Увс аймгийн Онцгой байдлын хэлтсийн 12 албан хаагч тус тус ажилласан байна.

Тайлангийн бусад зүйл заалтыг дэмжиж байна.

Таныг хүндэтгэсэн,

ДАРГА



Ц.АМГАЛАНБАЯР

D:/My documents/Blank/2012/A-4-3doc

000092621

Хил  
хамгаалах  
ерөнхий  
газрын  
санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР**

13343 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Б.Доржийн гудамж, Утас: 26-66-38, Факс: (976-51) 26-41-43  
E-mail: border\_pgb@bpo.gov.mn, http://bpo.gov.mn

2012.07.19 № 1-2/3019  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ГАНБИЛЭГ  
ТАНАА

Танай байгууллагаас ирүүлсэн “Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжөөр ХХЕГ-ын дарга, ХЦ-ийн командлагчид өгөх чиглэлийг “Хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Увс аймгуудын хилийн шугамын дагуу ойн зурвасыг шинээр байгуулах, сэргээх, хилийн отряд, заставуудыг түймэр унтраах зориулалтын техник, багаж хэрэгслээр хангах асуудлын хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газарт уламжилж шийдвэрлүүлэх, зохион байгуулах” гэж өөрчлөн найруулах саналтай байна.

Тайлбар 4

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА БӨГӨӨД  
ХИЛИЙН ЦӨРГИЙН ШТАБЫН ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

А.ЛХАГВАСҮРЭН - *ал*



Үндэсний аудитын газрын тайлбар

Тайлбар 1

Саналыг хүлээн авч зөвлөмжид орууллаа.

Тайлбар 2

Саналыг хүлээн авч зөвлөмжид орууллаа.

Тайлбар 4

Саналыг хүлээн авч тайланд тусгав.

**Хил орчмын бүс нутгийн хүрээлэн буй орчныг хамгаалах  
талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдалд  
ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын  
газраас хийсэн зэрэгцээ аудитын үр дүнгийн тухай  
санамж бичиг**

2012 оны 10 дугаар сарын 1-ний өдөр

Улаан-Үүд хот

Цаашид Талууд гэгдэх ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын газар “Хил орчмын бүс нутгийн хүрээлэн буй орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдалд ОХУ-ын Тооцооны танхим, Монгол Улсын Үндэсний аудитын газраас хийх зэрэгцээ аудит (Буриадын БНУ-ын Тооцооны танхимтай хамтран)” сэдэвт шалгалт хийв.

Зэрэгцээ аудитыг ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын газрын хооронд хамтран ажиллах тухай 2003 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хэлэлцээр, Зэрэгцээ аудит хийх тухай ОХУ-ын Тооцооны танхим, Монгол Улсын Үндэсний аудитын газрын хоорондын 2012 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн хэлэлцээрт үндэслэн гүйцэтгэсэн. Шалгалтын арга зүй Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (ИНТОСАИ)-аас баталсан хяналт шалгалтын хэм хэмжээ, зарчимд үндэслэгдсэн болно.

**Нэгдүгээр зүйл**

Талууд өөр өөрсдийн үндэсний хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэсэн зэрэгцээ аудит нь ОХУ, Монгол Улсын байгаль орчныг хамгаалах салбарт төрийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэхэд дөхөм үзүүлэх зорилгыг иш үндэс болгов.

**Хоёрдугаар зүйл**

Талууд зэрэгцээ аудитын үр дүнгийн талаарх тайлангаа тус тусдаа бие даан бэлтгэсэн. Тал тус бүр зөвхөн өөрийн тайлангийн агуулгыг хариуцна. Санамж бичигт аудитын тайлангийн гол дүгнэлтүүдийг тусгав.

**Гуравдугаар зүйл**

Талууд дараах үр дүнд хүрэв.

**Нийтлэг үндэслэл**

Талууд ОХУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газрын хооронд 1994 оны 2 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан “Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээр (цаашид 1994 оны 2

дугаар сарын 15-ны өдрийн хэлэлцээр гэх), ОХУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газрын хооронд 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” хэлэлцээр (цаашид 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хэлэлцээр гэх)-ээр тогтоосон хэм хэмжээнүүдийг биелүүлэхийн чухлыг тэмдэглэж байна.

Талууд хил орчмын нутаг дэвсгэрийн байгаль орчинд болон хил дамнасан усан объектуудын байдалд тавих хяналтын үүрэг роль ихийг тэмдэглэхийн зэрэгцээ, экологийн мониторингийн мэдээллийг цаг тухайд нь тогтмол харилцан солилцох, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг урьдчилан сэргийлэх талаар цогц арга хэмжээ авах нь ОХУ, Монгол Улсын төрийн байгууллагуудын ажлын чухал хэсэг болохыг хүлээн зөвшөөрөв.

### **ОХУ-ын Тооцооны танхимын аудитын үр дүн**

Хил дамнасан усыг хамгаалах, зохистой ашиглах талаарх орос-монголын хамтын ажиллагаа 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газар хоорондын Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байна.

1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Хэлэлцээрт тусгагдсан үүргүүд шалгалтад хамрагдсан хугацаанд бүрэн хэмжээгээр биелэгдсэн байна. Гэхдээ хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгох ихээхэн нөөц бололцоо байгааг шалгалт харууллаа. Тухайлбал, энэхүү хэлэлцээрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ОХУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар бүрэн эрхт төлөөлөгчдийг томилсон бөгөөд тэд зөвлөгөөнөөрөө холбогдох шийдвэрүүдийг хэлэлцэж байна. Гэвч бүрэн эрхт төлөөлөгчийн статус болон түүний шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалт-эрх зүйн механизм тодорхой бус байна.

Усан объектуудад хийх төрийн мониторингийн арга зүйг боловсронгуй болгох талаар цаг тухайд нь арга хэмжээ аваагүй баримтууд байна.

Иж бүрэн үнэлгээ ёсоор, хил дамнасан усан объектуудын бохирдлын зэрэглэл тогтвортой бөгөөд чанарын 3 дугаар ангилалд хамаарч, дээрх усан объектууд “бохирдолтой” ба “маш бохирдсон” гэж тодорхойлогдож байна.

Хил дамнасан усан объектуудыг бохирдуулагч үндсэн эх сурвалжууд нь усан суваг, орой сууц-нийтийн аж ахуйн байгууллагууд, нефть бааз, уул уурхайн аж ахуйн нэгжүүд юм. Нилээд их бохирдол (ялангуяа газрын тосны бүтээгдэхүүнээр) нь усан объектуудын дэргэдүүр өнгөрөх төмөр зам болон авто зам, мөн усан тээврийн үйл ажиллагаатай холбоотой байна.

Хил орчмын бүсэд ариун цэвэр-халдварын нөхцөл байдал тогтворгүй, цэвэрлэх байгууламжуудын байдал хангалтгүй, хил дамнасан усан объектууд, урсац, усны хамгаалалтын бүсийн нөхцөл байдлыг үнэлэх шаардлагууд (шалгуурууд)-ын нэгдсэн системийн мөрдөлтөд хяналт тавьж буй ОХУ болон Монгол Улсын төрийн бүх байгууллагуудын харилцан

уялдааг хангах шаардлагатайг хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хийгдэж буй хяналт шалгалтын үйл ажиллагаа харуулж байна.

Орос-Монголын хамтын ажиллагаа 1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байна. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор орос-монголын хамтарсан комисс байгуулагдсан бөгөөд тэр нь зөвхөн 2000 ба 2008 онд л хуралджээ.

Хил орчмын бүс дэх ой, хээрийн түймрээс урдъчилан сэргийлэх талаар ОХУ ба Монгол Улсын авсан арга хэмжээнүүд хил дамнасан түймрийг шуурхай унтраах боломж олгохгүй байгаа нь шалгалтын явцад тогтоогдлоо. Үүний зэрэгцээ сонирхогч бүх байгууллагуудыг уялдуулан зохицуулж, түймрийн голомт, түүний тархац болон гал унтраахад шаардагдах болон бэлэн байгаа хүч, хэрэгслийн талаарх мэдээллээр тэднийг шуурхай хангах нь хил орчмын бүс дэх түймрийн тоог багасгах боломж олгох юм.

Ойн түймрийн техник, тоног төхөөрөмжүүд ихээхэн элэгдэж хуучирсан, агаараас түймэр унтраах албаны ажилтнуудын орон тоо дутмаг, ойн харилцааны салбарт ОХУ-ын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэх явц дахь санхүүжилтийн механизм боловсронгуй бус байгаа нь түймрийг цаг тухайд нь илрүүлж, унтраахад сөргөөр нөлөөлж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Түүнчлэн ихэнх ховор амьтдын бүлэглэл хил дамнасан шинжтэй бөгөөд тэднийг хууль бусаар агнах явдал ихэссэн нь ОХУ ба Монгол Улсын байгаль хамгаалах хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн санхүүжилтийг холбооны төсвөөс болон ОХУ-ын субъектүүдийн төсвөөс гаргаж иржээ. Усны аж ахуйн ихэнх арга хэмжээнүүдийг 2012 оноос эхлэх хөтөлбөр-зорилтот удирдлагын аргын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

### **Монгол Улсын Үндэсний аудитын газрын аудитын үр дүн**

1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Хэлэлцээр ерөнхийдөө амжилттай хэрэгжиж байна. Хэлэлцээр батлагдсанаас хойш хил дамнасан усны талаар мэдээлэл солилцох ажил тогтмолжсон байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрээс урсан гарч буй Сэлэнгэ, Зэлтэр, Хяраан болон Хүдэр голуудын усны чанарын шинжилгээний үр дүн нь үндсэн бохирдуулагч бодисууд нормативт хэмжээнээс хэтрээгүй болохыг нотолж байна. Үүнтэй ижил үзүүлэлтүүд ОХУ-ын нутаг дэвсгэрээс урсаж ирж буй голуудын усанд мөн адил тэмдэглэгдсэн бөгөөд гэхдээ эдгээр голуудын усан дахь химийн зарим элементийн агууламж үндэсний стандартын шаардлагуудад нийцэхгүй байна.



Сэлэнгэ, Орхон, Онон голуудын дундаж урсац сүүлийн 15 жилд тогтвортой байжээ.

1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хэлэлцээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн, хил дамнасан түймэртэй тэмцэх арга хэмжээнүүд ажилтнуудыг сургах, мэдээлэл солилцох төдийгөөр үндсэндээ хязгаарлагдаж байгаа нь илт хангалтгүй юм.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн газар, Буриадын БНУ-ын Ойн аж ахуйн агентлаг, Тувагийн БНУ-ын Ойн аж ахуйн Улсын хороо, ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаарын Улсын ойн албаны хооронд 2010 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан санамж бичгийн хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн боловч зарим арга хэмжээ зохих үр дүнд хүрээгүй байна. Хилийн шугамын дагуух түймрээс урьдчилан сэргийлэх зурвас арилснаас ой, хээрийн түймэр хил хялбархан давж, экологи, эдийн засгийн хохирол учруулж байна. Түймэрт нэрвэгдсэн ойн сангийн экологи-эдийн засгийн хохирлыг тодорхойлох, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажил хангалтгүй хийгдэж байна.

1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хэлэлцээрт тусгагдсан ургамал, амьтныг хамгаалах, судлах, нөхөн сэргээх талаарх заалтууд хангалтгүй хэрэгжиж байна.

Монгол Улсын Засгийн Газар ОХУ-тай хамтран Хөвсгөл-Түнхэн, Онон-Сохонд зэрэг газруудыг хамруулан хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг болон Олон улсын шим мандлын нөөц газрыг байгуулахыг зорьж байна. Харамсалтай нь энэ ажил удааширч байна.

### **Ерөнхий үнэлгээ**

Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зохион байгуулалт-эрх зүйн механизмуудын статус, төлөөлүүлсэн бүрэн эрх тодорхой бус бөгөөд тэдгээрийг боловсронгуй, тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна.

Сүүлийн таван жилд ОХУ ба Монгол Улс хил дамнасан усан объектуудад хүний үйл ажиллагааны нөлөөллийг бууруулах, тусгай хамгаалалттай газар нутгийг дэмжих талаар тодорхой ажил хийжээ. Гэхдээ экологийн аюулгүй байдлыг хангахын тулд цаашид нэмэлт, үр нөлөөтэй арга хэмжээ авах шаардлагатай.

Талууд экологийн мониторингийн мэдээллийг харилцан солилцох асуудлыг журамлаж зохицуулах, байгаль хамгаалах хууль тогтоомжийг

5

хэрэгжүүлэх чиглэлээр ОХУ ба Монгол Улсын хянан шалгах байгууллагуудын хоёр талын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатайг тэмдэглэж байна.

#### Дөрөвдүгээр зүйл

Талууд ОХУ болон Монгол Улсын Засгийн газарт дараах зөвлөмжийг өгөх нь зүйтэй гэж үзэж байна:

хил дамнасан түймрийг унтраах талаар авч буй арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийж, хил орчмын бүс нутагт ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар Засгийн газар хоорондын баримт бичгийг батлах боломжийг судлах;

1994 оны 2 дугаар 15-ны өдрийн “Байгаль орчны салбарт хамтран ажиллах тухай”, 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх зохион байгуулалт-эрх зүйн механизмыг боловсронгуй болгож, тэдгээрт зохих статус, бүрэн эрх олгох;


хамтарсан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.

#### Тавдугаар зүйл

Талууд ОХУ болон Монгол Улсын хүрээлэн буй орчныг хамгаалах төрийн зохицуулалтын талаарх шалгалтын үр дүнг хэрхэн үр нөлөөтэй хэрэгжүүлснийг судлах зорилгоор 2015 онд зэрэгцээ аудитыг давтан хийхээр тохиролцов.

Энэхүү санамж бичгийг 2012 оны 10 дугаар сарын 1-ний өдөр орос, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй болно.

Монгол Улсын  
Ерөнхий аудиторын орлогч



Б.Батбаяр

ОХУ-ын  
Тооцооны Танхимын дарга



С.В.Степашин

## РЕШЕНИЕ

совместного заседания Коллегии Счетной палаты Российской Федерации и Совета Генерального аудитора Национального управления по аудиту Монголии

Об итогах контрольного мероприятия «Параллельная проверка Счетной палаты Российской Федерации и Национального управления по аудиту Монголии эффективности государственного регулирования в области охраны окружающей среды (совместно со Счетной палатой Республики Бурятия)».

Коллегия Счетной палаты Российской Федерации и Совет Генерального аудитора Национального управления по аудиту Монголии приняли решение:

1. Одобрить и подписать Меморандум о результатах параллельной проверки эффективности государственного регулирования в области охраны окружающей среды, проведенной Счетной палатой Российской Федерации и Национальным управлением по аудиту Монголии.

2. Поддержать совместное предложение Заместителя Генерального аудитора Монголии Б.Батбаяра и члена Коллегии Счетной палаты Российской Федерации М.В.Одинцова о направлении Меморандума о результатах параллельной проверки в:

Правительство Российской Федерации;

Правительство Монголии;

Государственную Думу Федерального Собрания Российской Федерации;

Совет Федерации Федерального Собрания Российской Федерации;

Великий Государственный Хурал Монголии;

Министерство природных ресурсов и экологии Российской Федерации;

Министерство окружающей среды и экологического развития Монголии;

Главное управление чрезвычайных ситуаций Монголии;

Главное управление пограничной охраны Монголии;

Хуралам Гражданских представителей и губернаторам приграничных аймаков Монголии.

2


3. Предусмотреть в Плане работы Счетной палаты Российской Федерации на 2015 год проведение совместно с Национальным управлением по аудиту Монголии повторного контрольного мероприятия по охране окружающей среды.

Председатель Счетной палаты  
Российской Федерации



С.В.Степашин

Заместитель Генерального аудитора  
Монголии



Б.Батбаяр



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2012 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 114


Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал”-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Дуламдорж, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн нарт хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Дуламдорж, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД